



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20²⁰ он ⁰⁶ дугаар
сарын ²³ ны өдөр

Дугаар ...²⁰⁸/₁₈₁₅

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу яамдын 2019 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд яамны үйл ажиллагаанд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Дүгнэлт, зөвлөмжид үндэслэн удаашралтай арга хэмжээг эрчимжүүлж зорилтот түвшинд хүргэх, хэрэгжилт хангалтгүй байгаа ажлуудыг анхаарч тодорхой үр дүнд хүргэж ажиллана уу.

Хавсралт ⁴⁶ хуудас.

Дэд дарга



У.БЯМБАСҮРЭН

2059533



**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
ЯАМНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
БОЛОН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН 2019 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ,
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР
2020 ОН**



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

АГУУЛГА

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
НЭГ. ЗОРИЛГО	5
ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ	5
ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	6
3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	6
3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	6
3.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	12
3.4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	14
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	17
4.1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	17
4.2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	18
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	21
5.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	21
5.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	25
5.3. Шударга байдлын түвшний үнэлгээ	27
5.4. Хэрэглэгчийн үнэлгээ	28
ЗУРГАА. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	29



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ОВОГ НЭР

ГАРЫН ҮСЭГ

АЛБАН ТУШААЛ

Э.Бат-Идэр

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

С.Нямбаяр

Засгийн газрын референт

Ш.Цэцэг-Өлзий

Засгийн газрын референт

Д.Бямбадулам

Засгийн газрын референт

А.Мөнхбат

Засгийн газрын референт

Б.Мөнх-Эрдэнэ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч

Ш.Энхцэцэг

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч

Р.Дүүрэнбаяр

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХЭ	Хувьцаа эзэмшигч
ХО	Хөрөнгө оруулагч
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

НЭГ. ЗОРИЛГО

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтүүдэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдийг хамруулсан. Үүнд;

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт,
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт,
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт;
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт.

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох:

- Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт,
- Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа.

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох:

- Ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа,
- Шилэн дансны хөтлөлт,
- Шударга байдлын түвшний үнэлгээ,
- Хэрэглэгчийн үнэлгээ зэрэг 10 үзүүлэлтүүдийг хамруулсан болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2, 6.3 –т заасан арга зүйгээр дээрх 10 үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн ирүүлсэн тайлангаас гадна холбогдох нэгж, байгууллагаас нэмэлт тодруулага авах, хамааралтай баримт бичиг болон статистик мэдээлэл, бусад байгууллагаас хийгддэг судалгааны дүнтэй харьцуулалт хийсэн болно. Мөн 2018 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзлээ.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцохдоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 4 үзүүлэлт нийт үнэлгээний 60 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 2 үзүүлэлт 20 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 4 үзүүлэлтийг 20 хувиар тус тус тооцсон. Эдгээр үзүүлэлтээс шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Сангийн яамнаас, шударга байдлын түвшний үнэлгээг Авилгатай тэмцэх газраас гаргасан үнэлгээг шууд авч ашигласан болно.



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:

Тус байгууллага хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажилд ач холбогдолтой хандаж, өгсөн дүгнэлт, зөвлөмж, сургалтаар олгогдсон мэдлэг, арга зүйг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах тал дээр сул байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн тайланг Сайдын зөвлөлийн хурлаар танилцуулсан тэмдэглэлийг тогтоосон хугацаанд ирүүлсэн ч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулгыг ирүүлээгүй байна. ЗГХШҮМС-д албан бичиг, хуралдааны тэмдэглэлийг оруулсан байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /unelgee.gov.mn/-д байршуулсан 116 шийдвэрийн 200 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нь 90.86 хувиар үнэлэгдэв.

	Нийт	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	116	14	6	5	4	50	27	3	6	1	-	-
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	200	32	14	16	9	69	39	10	6	3	-	-
Бүрэн хэрэгжсэн	100%	148	17	10	17	61	34	4	5	3	-	-
Хэрэгжих шатанд	70%	43	11	3	-	16	5	6	1	-	-	-
Хэрэгжилт хангалтгүй	30%	6	2	-	2	-	-	-	-	-	-	-
Хэрэгжээгүй	0%	1	-	1	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	2	2	-	-	-	-	-	-	-	-	-
Билэлтийн дундаж	90.86	84.33%	86.43%	92.63%	96.25%	91.01%	96.15%	82%	95%	100%	-	-

Хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, хэрэгжих боломжгүй заалтуудыг нэг бүрчлэн шүүж хяналтаас хасуулах саналаа системийн “Хүчингүй болсон буюу хяналтаас хассан тухай тэмдэглэл, өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлттэй эсэх” гэсэн хэсэгт тэмдэглэл хийн хяналтаас хасуулах талаар 2019 оны 3 дугаар улиралд сануулсан бөгөөд дахин нягтлах шаардалагтай.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж өөрийн харъяа байгууллага, газар, хэлтэстээ дүгнэлт, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулж, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх ажлыг уялдаа холбоотой зохион байгуулж, үр дүнг тооцох тал дээр сул байна.

Удаашралтай, тасарсан заалтуудын тоо өмнөх онуудтай харьцуулахад буурсан ч хэрэгжилтийн явцыг бус үр дүнг чухалчилж тайлагнах байдалд ахиц гаргах шаардлага байгаа нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайлангийн үнэлгээ, үр дүнгээс харагдаж байна.

ЗГХЭГ-аас 2018 оны жилийн эцсийн тайланд хийсэн дүгнэлт зөвлөмжтэй танилцан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг дараагийн тайлангийн танилцуулгад тусгаж ирүүлж байх гэсэн ажлыг дутмаг хэрэгжүүлсэн гэж үзэв.



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

Дараах арга хэмжээг эрчимжүүлэх арга хэмжээ авч хэрэгжилтийг хангуулах шаарлагатай.

УИХ-ын тогтоол				
1	2017 №46. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	1.8.. Тусгай хэрэгцээт боловсролын байгууллагын багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгах;	Мөн тус сургууль нь цэцэрлэгчийн анги нээн ажиллуулж 10 сурагч суралцаж байна. Дэлхийн банкны санхүүжилтээр Ерөнхий боловсролын 63 дугаар сургууль мужааны мэргэжил, ур чадвар олгох цех байгуулан хүүхдүүдийг сургаж, бүтээгдэхүүн гаргаж эхлээд байна.	100% 0% Бодитой, хамаарал бүхий асуудлыг тайлагнахад анхаарах.



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 121 дугаар тогтоолд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны үндсэн хэрэгжүүлэгчээр заасан арга хэмжээнд үндэслэсэн болно.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаас Засгийн газарт өгсөн чиглэл, Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаас Засгийн газрын гишүүдэд өгсөн үүргийн дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжилт нь удааширч байгаа зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж 2020 оны зорилтот түвшинд хүргэхийг зөвлөж байна.

Байгууллагын нэр	Өөрийн ирүүлсэн үнэлгээ	ЗГХЭГ-аас үнэлсэн үнэлгээ	Тоо	Ү/Б	0	40	70	100
БСШУСЯ	88.94	79.55	135	1	1	19	50	64

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ
/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам/

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтын дугаар		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин
3.2.20. “Боловсролын зээлийн сан” шинээр байгуулж, оюутан, суралцагчид үндэсний тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжийн үйлчилгээг үзүүлэх тогтолцоог ил тод, нээлттэй болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	3.2.20.	1	“Боловсролын зээлийн сан” шинээр байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх	Жил бүр дунджаар 75000 оюутан хамрагдах	Боловсролын зээлийн сангаар оюутан, суралцагчдад тэтгэлэг, зээл, тусламж олгоход гадаадад суралцаж буй 283 оюутанд 17,5 төгрөгийн зээл, дотоодод 9555 оюутанд 13,7 тэрбум төгрөгийн зээл, 1466 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 1,4 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан өрхийн 4811 суралцагчид 4,6 тэрбум төгрөг, нэг өрхийн 3 дахь суралцагчид 579 суралцагч, 595,6 сая төгрөг, багш мэргэжлээр элсэгч болон суралцагч 2472 оюутанд 1,7 тэрбум төгрөг, Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу Монгол улсад суралцаж байгаа гадаадын 285 оюутанд 800,7 сая төгрөгийн, “Оршин суугаа газраасаа 500 километр болон түүнээс хол байршилтай 10911 суралцагч 1,0 тэрбум төгрөг, цаатан иргэдийн гэр бүлээс суралцагч 8 суралцагчийн 6,1 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.
3.2.30. Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, инновацын гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.	3.2.30.	2	Инновацийн бүтээгдэхүүн бий болгох, үйлдвэрлэл явуулах таатай орчин бүрдүүлэх	Жагсаалт батлагдах	Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” 234 дугаар тогтоолоор “Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт” батлагдсан.



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтын дугаар		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин
3.2.30. Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, инноваци, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.	3.2.30.	3	Инноваци, гарааны бизнесийг дэмжих зорилгоор төсөл хэрэгжүүлэх	Инновацийн төсөл хэрэгжих	Засгийн газрын 2018 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан "Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам"-ын дагуу инновацийн төсөл хэрэгжүүлэгчдээс холбогдох материалуудыг хүлээн авч, 2019 онд грант олгох инновацийн төслүүдийг сонгон шалгаруулсан. Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргах, эдийн засгийн үр ашиг, өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулах зорилго бүхий 5 төсөлд шинжээчдийн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн тус бүр 60 сая, нийт 300 сая төгрөгийн грант олгох шийдвэрийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/326 дугаар тушаалаар баталсан. Эдгээр 5 инновацийн төсөл хэрэгжүүлэгчидтэй гэрээ байгуулан, судалгаа, туршилтын ажлуудыг эхлүүлээд байна
3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.	3.2.33.	2	Туршилтын үйлдвэр, технологи дамжуулах төв, бизнес инкубатор зэрэг инновацийн дэд бүтэц байгуулах ажлыг зохион байгуулах	Туршилтын үйлдвэр байгуулагдах	Технологи дамжуулах төв, бизнес инкубатор зэрэг инновацийн дэд бүтэц байгуулах төлөвлөгөөний төслийг боловсруулав. Азийн хөгжлийн банкны "Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх" төслийн хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг тоног төхөөрөмжөөр хангах бэлтгэл ажил хийгдэж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Дээд боловсролын шинэчлэлийн төсөл"-ийн санхүүжилтээр 2018 онд Монгол Улсын их сургуульд орчин үеийн судалгааны шаардлагад нийцсэн 3 тэрбум төгрөгийн өртөг бүхий Лазерын лабораторийг байгуулсан.
3.2.34. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд үндэслэн хувийн хэвшлийн оролцоонд тулгуурласан Хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулж, инновацийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх тааламжтай бүтцийг бүрдүүлнэ.	3.2.34.	1	Төр, хувийн хэвшлийн хамтарсан хэлбэрээр инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулах санал боловсруулах	-	2013 оны "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль", Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны "Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам батлах тухай" 08, "Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам" 175, "Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам" 254 тоот тушаалыг тус тус үндэслэн "хамтын хөрөнгө оруулалтын сан"-г үүсгэн байгуулах эрх зүйн орчин бүрдсэн. 2017 онд 3 хөрөнгө оруулалтын менежментийн компани болон 4 хөрөнгө оруулалтын сан байгуулах тусгай зөвшөөрөл олгож, бүртгэсэн.
3.2.36. Салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх өндөр технологийн судалгаа ба хөгжил, инновацийн болон зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааны суурь бүтцийг хөгжүүлэх, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.	3.2.36.	2	Шинжлэх ухааны паркийг байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулах	ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг эхлүүлэх	Шинжлэх ухааны паркийн техник эдийн засгийн урьдчилсан судалгааг Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн өнөөгийн байдал, бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан парк байгуулснаар бий болох үр нөлөө, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, гадаад орнуудын туршлага, холбогдох судалгаанд үндэслэн боловсруулсан. Эдгээр урьдчилсан судалгааны ажлууд дээр үндэслэн "Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах техник, эдийн засгийн үндэслэл" боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж дууссан.
3.2.49. Хөдөө орон нутагт хэрэгцээ, шаардлага, үйлчилгээний чанар, үр	3.2.49.	1	Орхон, Баянхонгор, Өмнөговь	Орхон, Баянхонгор, Өмнөговь	Орхон, Баянхонгор аймгийн музейн барилгын зураг төсөв, техникийн дүгнэлтийг бэлтгэж бэлэн болгосон, 2018 онд Өмнөговь аймгийн музейн



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтын дугаар		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин
дүнтэй уялдуулан соёл урлагийн барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай зохион байгуулна.			аймгийн музейн барилгыг шинээр барих	аймгийн музейн барилга угсралтын ажлыг дуусгах	барилгыг орон нутгийн хөрөнгөөр барьж эхэлсэн бөгөөд барилга угсралтын ажил 90 орчим хувьтай явагдаж байна.
3.2.49. Хөдөө орон нутагт хэрэгцээ, шаардлага, үйлчилгээний чанар, үр дүнтэй уялдуулан соёл урлагийн барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай зохион байгуулна.	3.2.49.	3	Увс, Ховд, Булган аймгийн Хөгжимт драмын театр, Говьсүмбэр аймгийн чуулгын барилгыг шинээр барих	Барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/ төсөл, арга хэмжээ 6.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдаж, барилга угсралтын ажил 20 орчим хувьтай явагдаж байна. Мөн Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Боржигон чуулгын гаднах талбайн тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум/ төсөл, арга хэмжээний 106.0 сая төгрөг батлагдаж, ажил хийгдэж байна.
3.2.49. Хөдөө орон нутагт хэрэгцээ, шаардлага, үйлчилгээний чанар, үр дүнтэй уялдуулан соёл урлагийн барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай зохион байгуулна.	3.2.49.	4	Зарим дүүргийн соёлын ордон, сумын соёлын төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах	3 соёлын ордон ашиглалтад орох	
3.2.51. Чойжин ламын сүм музейг шинэчлэн засварлаж, Тоньюкукын цогцолборыг хамгаалах, музей байгуулах, Шороон бумбагарын бунхант булш, ханын зургийг хамгаалах, сэргээн засварлах, Эзэнт гүрэн музей байгуулах ажлыг зохион байгуулна.	3.2.51.	2	Тоньюкукын цогцолбор дурсгалыг хамгаалж, музей байгуулах	Музейн барилга угсралтын ажлыг дуусгах	Тоньюкукийн цогцолбор дурсгалыг малтан судлах, хамгаалах арга хэмжээг 2015 оноос эхлэн хэрэгжүүлж байна. 2016 онд хоёр талын археологчдын баг цогцолборын бүтцийг илрүүлэх зорилгоор өргөн хэмжээний малтлага судалгаа хийж дууссан. 2017 онд хоёр тал цогцолбор дурсгалын малтлагын үр дүнг бэхжүүлэх, музейн барилгын зураг төслийн боловсруулах ажлууд хийгдэж байна. Хоёр тал музейн барилга барих, дотор гадна тохижилтын ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтарсан протокол байгуулж ажиллахаар урьдчилан тохиролцож, төслийг боловсруулаад байна. Музейн барилга угсралтын ажлыг 2020 оноос эхлүүлэхээр төлөвлөж байна.
3.2.51. Чойжин ламын сүм музейг шинэчлэн засварлаж, Тоньюкукын цогцолборыг хамгаалах, музей байгуулах, Шороон бумбагарын бунхант булш, ханын зургийг хамгаалах, сэргээн засварлах, Эзэнт гүрэн музей байгуулах ажлыг зохион байгуулна.	3.2.51.	3	Шороон бумбагарын бунхант булш, ханын зургийг хамгаалж, музей байгуулах	Музейн барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Шороон бумбагар бунхант булш, ханын зургийг авран хамгаалах, сэргээн засварлах төсөл"-ийн гэрээний хүрээнд 2016 онд ханын зургийг хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг дэд бүтцээр хангах ажлуудыг хийв. 2018 онд Шороон бумбагарын бунхант булш, ханын зургийг хамгаалахад шаардлагатай дэд бүтцийг барьж дуусгах ажлын хүрээнд хамгаалалтын барилгыг сунгах, агааржуулалтын систем суурилуулах, модон баганыг эзвэрдэггүй металл баганаар солих ажлуудыг хийж дуусгаад байна.
3.2.53. Спортын төв ордныг шинэчилж, олон улсын стандартад нийцсэн хөнгөн атлетикийн тартанан зам, өвлийн спортын ордон барина.	3.2.53.	4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын ордон барих	-	БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдах Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын ордны барилгын ажил 2018 онд эхлэх бөгөөд Хятадын талын судалгааны баг ирж, барилгын ажлыг гүйцэтгэхэд холбоотой төрийн байгууллагуудтай зохих уулзалт хийн гэрээ байгуулахыг хүлээж байна
3.2.57. Үндэсний соёл, урлагийг шинэ шатанд гаргах зорилгоор "Үндэсний байгалийн музей, театр,	3.2.57.	4	Циркийн сургуулийн барилгыг шинээр барьж,	Циркийн сургуулийн барилгыг үргэлжлүүлэх	



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтын дугаар		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин
урлагийн цогцолборууд"-ыг байгуулж, соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.			Хөгжмийн их сургууль шинээр байгуулах	х, Хөгжмийн их сургуулийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх	
3.2.57. Үндэсний соёл, урлагийг шинэ шатанд гаргах зорилгоор "Үндэсний байгалийн музей, театр, урлагийн цогцолборууд"-ыг байгуулж, соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.	3.2.57.	7	Хүүхдийн төв номын сангийн барилгыг шинээр барих	Барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	
3.2.59. Үндэсний урлагийг дэмжих бодлогын хүрээнд Үндэсний урлагийн Их театр барих ажлыг эхлүүлнэ.	3.2.59.	1	Үндэсний урлагийн Их театр барих ажлыг эхлүүлэх	Барилга угсралтын ажлыг эхлүүлэх	"Үндэсний урлагийн их театрын барилгын зураг, төсөв боловсруулах" төслийг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендер зарлаж "Building's technology" ХХК шалгаран барилгын зураг төслийн ажлыг гүйцэтгэж байна. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд тус театрын барилгыг 152,520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тус онд санхүүжих дүн 5,000.0 сая төгрөгөөр баталсан.




Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

3.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Улсын Их Хурлын 2018 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 37 дугаар тогтоолоор баталсан бөгөөд Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан ажиллаа.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 5 бодлого, 20 зорилт, 135 арга хэмжээний хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар **78.0** хувьтай гарлаа.

График 1. Үндсэн чиглэлийн жилийн биелэлт бодлогоор, эзлэх хувь хэмжээ



Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн нийт 135 арга хэмжээнээс:

- 63 арга хэмжээ 100 хувь,
- 48 арга хэмжээ 70 хувь,
- 14 арга хэмжээ 40 хувь,
- 6 арга хэмжээ 0 хувьтай үнэлэгдэж,
- 4 арга хэмжээ үнэлэх боломжгүй байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Үндсэн чиглэлийн биелэлтэд Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийсэн бөгөөд аудитын дүгнэлт, зөвлөмжтэй танилцана уу.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах **ДҮГНЭЛТ**-ийг хийж байна. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зарим арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, журамд нийцүүлэн тооцоо судалгаанд үндэслээгүй, хэрэгжих боломжтой хугацаа, шалгуур үзүүлэлт,



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

хүрэх түвшнийг оновчтой тогтоохгүйгээр төлөвлөсөн зөрчил жил бүр давтагдсаар байна.

- Баталсан арга хэмжээ бүрд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн бодитой тооцоогүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутагдаж, төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй, дутуу хэрэгжих үр дагавар үүсэж байна.

- Үндсэн чиглэлийн арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд багтаан хэрэгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх асуудлыг холбогдох байгууллагууд хангалттай зохион байгуулаагүй, ЗГХЭГ-аас 2019 оны эхний хагас жилд хийсэн үнэлгээгээр өгсөн үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

- ҮАГ-аас 2013-2018 онд үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар УИХ, ЗГХЭГ, Сангийн яам болон бусад хэрэгжүүлэгч яам, агентлагуудад дээр дурдсан зөрчлийг арилгах, хамтран хэрэгжүүлэгч яам, байгууллагуудын ажлын уялдаа холбоо, ажлын хариуцлагыг сайжруулах зөвлөмжийг жил бүр өгсөн боловч зөрчлүүд дахин давтагдан гарсаар байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд: **Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээг хууль, журамд нийцүүлэн тухайн жилд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх;

Үндсэн чиглэлийн арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, биелэлтийн тайланд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хүрсэн түвшнийг журамд нийцүүлэн бүрэн тодорхойлж тайлагнах;

Аудитын тайланд тусгагдсан хэрэгжээгүй, дутуу хэрэгжсэн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангахад анхаарч, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлж ажиллах.

/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтэд Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсаргав./



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

3.4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 2019 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайлагналтыг авч үзэхэд 37 үзүүлэлтийн гүйцэтгэл ирүүлэхээс 36 үзүүлэлтийн гүйцэтгэл ирүүлж тайлагнасан байна. Монгол Улсын сайд, Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд зорилтын биелэлт **91.32** хувьтай гарсан байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	ЗГХЭГ-аас өгсөн үнэлгээ
		2016	2019	2019	2019
I. БОЛОВСРОЛЫН САЛБАР					
1	Хамран сургалтын хувь				
	Сургуулийн өмнөх боловсрол	80.80	83.30	84.20	100.0%
	Бага боловсрол	96.9	97.6	96.8	99.2%
	Суурь боловсрол	95.60	96.20	97.50	100.0%
2	Шинээр барьж байгуулах, өргөтгөх сургууль, цэцэрлэг				
	Ерөнхий боловсролын сургууль (нэмэгдсэн суудлын тоо)	8,968	25,678	20,635	80.4%
	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр (нэмэгдсэн орны тоо)	670.0	1,445.0	1,420	98.3%
	Цэцэрлэг (нэмэгдсэн суудлын тоо)	2120.00	13770.00	14,361	100.0%
	Гэр цэцэрлэг (нэмэгдсэн суудлын тоо)	725.0	-	-	
3	Мэргэжлийн багшийн хангалтын хувь				
	Сургуулийн өмнөх боловсролын багш	95.7	98.7	91.1	92.3%
	Ерөнхий боловсролын сургуулийн багш	98.60	97.60	97.30	99.7%
4	Нэг компьютерт ногдох хүүхдийн тоо (ерөнхий боловсролын сургууль)	12.9	12.4	9.1	100.0%
5	Дээд боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдын дотуур байрны хангалт				
	Дотуур байранд суухаар саналаа өгсөн оюутны тоо	12,950.0	14,900.0	14,486.0	97.2%
	Сургуулийнхаа дотуур байранд амьдардаг оюутны тоо	11198.00	12800.00	12,435.0	97.1%
	Дотуур байрны хангалтын хувь	84.5	86.0	91.8	100.0%
6	Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадын сургуульд элсэгчдийн тоо	1450.00	1600.00	1,445	90.3%
7	Боловсролын зээлийн сангаас зээл авсан оюутны тооны өсөлт	-	36,000.0	28,297	78.6%
8	Оюутнууд харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээ авсан тоо	36000.00	40000.00	117,272	100.0%



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	ЗГХЭГ-аас өгсөн үнэлгээ
		2016	2019	2019	2019
9	Өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа өрхийн оюутанд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн тоо	1,500.0	1,500.0	298.0	19.9%
II. СОЁЛЫН САЛБАР					
1	Соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн өсөлтийн хувь	5.0	10.0	10.0	100.0%
2	Мэргэжлийн соёл, урлагийн байгууллагад шинээр болон сэргээн тавьсан бүтээлийн тоо	20.00	30.00	29.50	98.3%
3	Шинээр баригдсан музей, театрын барилгын тоо				
	Театр	4.00	28.00	0.00	0.0%
	Музей	-	3.0	2.0	66.7%
	Номын сан	0.00	1.00	1.00	100.0%
	Соёлын төв	4.0	23.0	24.0	100.0%
4	Сэргээн засварласан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн тоо	200.00	400.00	1213.00	100.0%
5	Соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	-	135,600.0	142,680.0	100.0%
III. ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАР					
1	Судалгаа, шинжилгээний ажил эрхэлж буй эрдэм шинжилгээний ажилтанд эрдмийн зэрэгтэй ажилтны эзлэх хувь	31.9	32.8	32.9	100.0%
2	Тухайн жилд шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт (сая төгрөг)	2825.30	6400.00	9500.00	100.0%
3	Тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтад хамаарах судалгаа боловсруулалтын ажил (хувь)	40.0	55.0	60.0	100.0%
4	Эрдэм шинжилгээний тоног төхөөрөмжийн паркийн шинэчлэлт	0.00	20.00	20.00	100.0%
5	Эдийн засаг, нийгэмд үр ашигтай оюуны бүтээлийг нэвтрүүлэх	50.0	50.0	91.0	100.0%
6	Судалгаа боловсруулалтын ажилд Засгийн газраас зарцуулах санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ /хувиар/	0.11	0.25	0.18	72.0%
IV. СПОРТЫН САЛБАР					
1	Нэг хүнд ногдох спортын барилга байгууламжийн талбайн хэмжээний өсөлт (м2)	0.20	0.30	0.28	92.6%
2	Спортоор хичээллэдэг хүүхэд, залуучуудын тоо	218,000.0	224,000.0	277,324.0	100.0%
3	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшний үнэлгээ				
	Сорилд хамруулах хүний тоо	389,140.0	400,000.0	398,414.0	99.6%



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	ЗГХЭГ-аас өгсөн үнэлгээ
		2016	2019	2019	2019
	Хамрагдсан нийт хүнд А, В үнэлгээтэй хүмүүсийн хувь	51.00	54.00	53.60	99.3%
	Хамрагдсан нийт хүнд С үнэлгээтэй хүмүүсийн хувь	26.0	28.0	27.5	98.2%
	Хамрагдсан нийт хүнд D үнэлгээтэй хүмүүсийн хувь	16.40	15.00	14.90	99.3%
	Хамрагдсан нийт хүнд F үнэлгээтэй хүмүүсийн хувь	6.0	4.9	5.2	100.0%

Дүгнэлт:

Төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл нь тухайн салбарт хамаарах эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь үзүүлэлт, судалгаа, тооцоон дээр тулгуурлан эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хүрэх түвшинг нэгдсэн байдлаар төлөвлөхгүй байгаагаас шалтгаалан салбар болон орон нутгийн бодлогын зорилт зөрүүтэй байна.

Түүнчлэн салбарын яам нь орон нутгийн түвшинд салбарын чиг үүргийг хэрэгжүүлэх нэгж, байгууллагыг нэгдсэн бодлогоор хангах ажиллагаа учир дутагдалтай байна. Үүний улмаас салбар болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хоорондын уялдаа холбоо сул байна.

Зөвлөмж:

1. Салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг холбогдох эх сурвалжаас авч, үнэн бодитой тайлагнаж байх;
2. Төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж өөрийн салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ суурь түвшин болон хүрэх түвшинд харьцуулан үнэлж байх;
3. Аймаг, нийслэлийн түвшинд салбарын нэгдсэн бодлогоор хангаж ажиллах, салбарын чиг үүргийг аймаг, нийслэлд хэрэгжүүлж буй байгууллага, нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн төлөвлөлтөд хяналт, шинжилгээ хийж, салбарын бодлоготой уялдуулах арга хэмжээг зохион байгуулах;
4. Цаашид салбарын бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж нь улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд дүн, шинжилгээ хийж, судалгааны үндсэн дээр салбар болон орон нутгийн түвшинд бодлогын зорилтыг тодорхойлж, салбарын хэмжээний иж бүрэн төлөвлөлтийг хийж байх.



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг **89.60** хувьтай гэж дүгнэв. Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой тусгах, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай арга хэмжээг дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой тусгах, шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлох, хүрэх түвшинг тухайн жилдээ биелэгдэх боломжтойгоор тодорхойлох шаардлагатай байна. Мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа салбарын стратеги төлөвлөгөөний зорилт, арга хэмжээн дээр үндэслэн оновчтой, бодитой, тодорхой байх, хэмжээний хувьд хэт нүсэр байдлаар хийхгүй байхад анхаарна уу.



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

4.2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10 дугаар хавсралтад туссан хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаарх 2 зорилт, 5 үйл ажиллагааны биелэлтийг үндсэн 10 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэв.

Зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг тооцохдоо хугацаандаа баталгаажуулан ирүүлсэн жилийн эцсийн хэрэгжилтийн тайлангийн чанарт үндэслэхийн зэрэгцээ шалгалт, сургалт, семинар, албан ажлаар яамдад ажиллах үед цуглуулсан мэдээлэл, бодит нөхцөл байдал, хөндлөнгийн судалгааны дүн зэргийг харгалзан үзсэн болно.

Хүний нөөцийг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх бодлогын 2019 оны гүйцэтгэлийг тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээлэл, дээр дурдсан бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж 76.67 хувь буюу 3.83 оноогоор үнэлэв.



Хүний нөөцийг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээрх 10 үзүүлэлтээс 7 үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн, 3 үзүүлэлт 30 хувьтай буюу зорилтот түвшинд хүрээгүй байна.

Тайлагнасан, үнэлгээ хийгдсэн үзүүлэлтийн хэрэгжилтийн байдал:

Үнэлгээний ангилал	Тоо	Эзлэх %
Хэрэгжээгүй (0%)	-	0%
Хэрэгжилт хангалтгүй (30%)	3	30%
Хэрэгжих шатанд (70%)	0	0%
Бүрэн хэрэгжсэн (100%)	7	70%




Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын биелэлт

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хэрэгжилтийн хувь	
				Өөрийн үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ
ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ					
1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	100.0	100.0
		Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	100.0	100.0
		Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	100.0	30.0
2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	100.0	30.0
Хэсгийн дундаж:				100.0	65.0
АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ					
3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	100.0	100.0
		Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	100.0	100.0
4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	100.0	30.0
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	100.0	100.0
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	100.0	100.0
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	100.0	100.0
Хэсгийн дундаж:				100.0	88.3
Үнэлгээний дундаж хувь				100.00	76.67

Зорилтот түвшинд хүрээгүй зарим үзүүлэлтээс дурдвал:



- Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх
- Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал

- Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

Дүгнэлт:

Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэв. Албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод, гадаад сургалт зохих түвшинд хийгдэж байгаа хэдий ч сургалтын хэрэгцээ шаардлага, агуулга, сэдэв, хамрах хүрээ, оролцогчдын бүртгэл, судалгаатай холбоотой мэдээллийг тайланд бүрэн тусгаагүй байна.

Ажилтан, албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөл, ажиллах орчны таатай нөхцөлийн талаарх санал асуулгыг зохион байгуулсан эсэх, санал асуулга чанартай хийгдсэн эсэх, асуулгын дүнгийн мөрөөр ямар арга хэмжээ авч ажилласан тухай мэдээлэл болон мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх зорилтыг хангах ажил хангалтгүй байна.

Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлсэн, Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд жил бүр хамруулах ажлыг тогтмолжуулсан гэж дүгнэв.

Зөвлөмж:

- Хүний нөөцийн сургалт, нийгмийн баталгааг хангах урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль болон уг хуулийг дагалдаж гарсан бусад эрх зүйн актад нийцүүлэн боловсруулж, албан хаагчдын санал, бусад оролцогч талуудын зөвлөмжийг тусган хэрэгжүүлэх,
- Дунд хугацаанд болон тухайн жилд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд товч, тодорхой тусгаж, холбогдох нотлох баримт, гарсан шийдвэр, бүртгэл судалгааг хавсралтаар дэлгэрэнгүй тайлагнах,
- Арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайланг нэгтгэх, хяналт-шинжилгээ хийхэд оролцож буй нэгж, албан тушаалтнууд нь өөрийн байгууллагын удирдлага болон Засгийн газрыг бодитой мэдээллээр хангахад анхааран ажиллах,
- Төрийн захиргааны төв байгууллагын хувьд салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, мэргэшсэн, тогтвортой төрийн албан хаагчдыг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажилд манлайлал гарган ажиллах,
- Мэргэшсэн, чадварлаг, тогтвортой төрийн албыг бүрдүүлэх бодлогыг төрийн байгууллагын зохистой хүний нөөцийг бүрдүүлэх үндсэн хөшүүрэг, хүчин зүйлс болгон ажиллахын зэрэгцээ энэ талаар холбогдох хууль тогтоомж, аргачлалд өөрчлөлт оруулах санал, хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаарх мэдээлэл зэргийг тухай бүр ирүүлж байхыг тус тус зөвлөмж болгож байна.




ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

5.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 11 дүгээр хавсралтад туссан “Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг Үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал гэсэн үндсэн 2 ангиллын 14 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэв.

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг тооцохдоо баталгаажуулан ирүүлсэн жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд үндэслэхийн зэрэгцээ шалгалт, сургалт, семинар, албан ажлаар яамдад ажиллах үед цуглуулсан мэдээлэл, бодит нөхцөл байдал, хөндлөнгийн судалгааны дүн, цахим хуудас, мэдээллийн самбарын хөтлөлт зэргийг харгалзан үзсэн болно.

Байгууллагын ил тод байдлыг хангах замаар иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах зорилтын 2019 оны гүйцэтгэлийг тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээлэл болон дээр дурдсан бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж 71.11 хувь буюу 3.56 оноогоор үнэлэв.



Ил тод байдлыг илтгэх 14 үзүүлэлтээс 2 үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн, 11 үзүүлэлт 70 хувь, 1 үзүүлэлт 30 хувьтай буюу зорилтот түвшинд хүрээгүй байна.

Тайлагнасан, үнэлгээ хийгдсэн үзүүлэлтийн хэрэгжилтийн байдал:

Үнэлгээний ангилал	Тоо	Эзлэх %
Хэрэгжээгүй (0%)	-	0%
Хэрэгжилт хангалтгүй (30%)	1	7%
Хэрэгжих шатанд (70%)	11	79%
Бүрэн хэрэгжсэн (100%)	2	14%



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлт

№	Шалгуур үзүүлэлт Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал	Хэрэгжилтийн хувь	
		Өөрийн үнэлгээ	ЗГХЭГ-ЫН үнэлгээ
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100.0	70.0
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100.0	30.0
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100.0	70.0
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100.0	70.0
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	100.0	100.0
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	100.0	100.0
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	100.0	70.0
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100.0	70.0
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	100.0	70.0
Хэсгийн дундаж хувь:		100.00	72.22



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь	
		Өөрийн үнэлгээ	ЗГХЭГ-ЫН үнэлгээ
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	100.0	70.0
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100.0	70.0
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	100.0	70.0
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	100.0	70.0
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	100.0	70.0
Хэсгийн дундаж хувь:		100.00	70.00

Зорилтот түвшинд хүрээгүй зарим үзүүлэлтээс дурдвал:



- Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн мэдээлэл
- Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар

- Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилт
- Албан хаагчийн ёс зүйн дүрэм
- Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

Дүгнэлт:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, 8 дугаар зүйл заасан хүний нөөцийн ил тод байдлын талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан төр засгийн мэдээлэл, үйлчилгээг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагад ойлгомжтой байдлаар, илүү хялбар, хурдан шуурхай хүргэх талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний хэрэгжилт, гарсан үр дүнг тооцон үзэхэд ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт тус бүрийн хэрэгжилт харилцан адилгүй байна.

Зөвлөмж:

- Бүрэн хэрэгжээгүй шалгуур үзүүлэлт бүрийн хэрэгжилтийг сайжруулах талаар төлөвлөгөө гарган ажиллах,
- Мэдээ мэдээллийн чанар, хүртээмжийг чанаржуулах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд товч, тодорхой тусгаж, холбогдох нотлох баримт, гарсан шийдвэр, бүртгэл судалгааг хавсралтаар дэлгэрэнгүй тайлагнах,
- Цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж буй мэдээллийн “холбогдолтой”, “цаг үеийн”, “найдвартай байдал”-д илүү ач холбогдол өгч, иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар байх зарчмыг баримтлан ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

5.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Нийт 53 ТЕЗ нарын мэдээллээс харахад, нэг төсвийн ерөнхийлөн захирагч дунджаар 100 орчим харьяа байгууллагатай ба 2019 онд нэг байгууллага дунджаар 150 удаа мэдээлэл байршуулахаас 145 орчим удаа мэдээлэл байршуулж, ТЕЗ нарын шилэн дансны хөтлөлт дунджаар **97.7%**-ийн биелэлттэй буюу шилэн дансны хуулийг ТЕЗ нар “хангалттай сайн” хэрэгжүүлж ажилласан байна. Доорх хүснэгтээс ТЕЗ тус бүрээр 2019 онд шилэн дансны цахим нэгдсэн системд байршуулсан мэдээллийн үнэлгээг үзнэ үү.

№	ТЕЗ нарын нэрс	Харьяа байгууллагын тоо	Мэдээлэл оруулах давтамжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Мэдээлэл оруулсан давтамжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Үүнд:		Хэрэгжилтийн хувь
					Хугацаандаа	Хугацаа хоцроосон	
1	Архангай аймаг	171	146	142	120	22	97.3%
2	Баян-Өлгий аймаг	159	145	131	121	10	90.3%
3	Баянхонгор аймаг	189	141	139	115	24	98.6%
4	Булган аймаг	164	145	144	134	10	99.3%
5	Дархан-Уул аймаг	90	145	140	136	4	96.6%
6	Дорнод аймаг	163	144	142	128	14	98.6%
7	Дорноговь аймаг	146	143	142	131	11	99.3%
8	Дундговь аймаг	144	145	142	119	23	97.9%
9	Говь-Алтай аймаг	178	145	140	132	9	96.6%
10	Говьсүмбэр аймаг	50	148	147	132	15	99.3%
11	Завхан аймаг	199	146	144	130	14	98.6%
12	Орхон аймаг	83	144	141	135	7	97.9%
13	Өвөрхангай аймаг	192	145	144	126	18	99.3%
14	Өмнөговь аймаг	176	145	143	123	20	98.6%
15	Сүхбаатар аймаг	136	147	140	114	26	95.2%
16	Сэлэнгэ аймаг	204	145	139	110	29	95.9%
17	Төв аймаг	230	146	142	126	15	97.3%
18	Увс аймаг	172	137	135	112	23	98.6%
19	Ховд аймаг	163	146	141	119	22	96.6%
20	Хөвсгөл аймаг	223	143	141	127	14	98.6%
21	Хэнтий аймаг	189	145	143	132	11	98.6%
22	БОАЖЯ	88	145	144	131	13	99.3%
23	БХБЯ	31	136	135	122	13	99.3%
24	БХЯ	86	143	139	138	1	97.2%
25	БСШУСЯ	178	144	141	102	39	97.9%
26	ГХЯ	45	142	140	128	12	98.6%
27	ЗТХЯ	90	119	109	102	7	91.6%
28	СЯ	80	129	128	113	15	99.3%
29	УУХҮЯ	14	97	95	78	17	97.9%
30	ХНХЯ	214	146	143	120	23	97.9%
31	ХЗДХЯ	212	142	139	134	5	97.9%
32	ХХААХҮЯ	66	142	141	113	28	99.3%



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

№	ТЕЗ нарын нэрс	Харьяа байгууллагын тоо	Мэдээлэл оруулах давтамжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Мэдээлэл оруулсан давтамжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Үүнд:		Хэрэгжилтийн хувь
					Хугацаандаа	Хугацаа хоцроосон	
33	ЭМЯ	165	145	144	130	14	99.3%
34	ЭХЯ	46	88	85	81	4	96.6%
35	ЗГХЭГ	16	123	122	99	23	99.3%
36	МУЕСайд	15	130	128	107	21	98.4%
37	Шадар сайд	91	140	139	132	7	99.3%
38	Авлигатай тэмцэх газар	1	206	200	196	4	97.1%
39	МУЕАудитор	23	145	142	135	7	97.9%
40	Ерөнхийлөгчийн Тамгын газар	3	145	140	114	26	96.6%
41	УИХ-ын Тамгын газар	2	145	142	120	22	97.9%
42	Үндсэн хуулийн цэц	1	145	143	113	30	98.6%
43	Санхүүгийн зохицуулах хороо	1	206	205	170	35	99.5%
44	Сонгуулийн ерөнхий хороо	2	145	143	143	-	98.6%
45	Төрийн албаны зөвлөл	1	164	161	150	11	98.2%
46	Улсын дээд шүүх	1	194	182	182	-	93.8%
47	Улсын ерөнхий прокурор	41	145	144	141	3	99.3%
48	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	2	145	142	121	21	97.9%
49	Үндэсний статистикийн хороо	23	145	143	141	2	98.6%
50	Хүний эрхийн үндэсний комисс	1	206	201	116	85	97.6%
51	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс	1	206	198	173	25	96.1%
52	Шүүхийн ерөнхий зөвлөл	41	145	143	134	9	98.6%
53	Нийслэл	596	140	134	85	49	95.7%
ДУНДАЖ ДҮН			147	143	126	17	97.7%

Жич: Монгол банк нь өөрийн байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлж байна. Мөн улс, орон нутгийн төсвөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн төрийн бус байгууллага, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгж, байгууллагыг дээрх үнэлгээнд хамруулаагүй болно.

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээгээр хуулийн хэрэгжилт хэдийгээр сайн байгаа боловч тогтоосон хугацаанд мэдээлсэн нь 88.0%-ийг эзэлсэн бөгөөд зөвхөн Сонгуулийн ерөнхий хороо, Улсын дээд шүүх хугацаандаа бүх мэдээллээ байршуулсан байна. Иймд цаашид тогтоосон хугацааг баримтлан мэдээллээ байршуулахад бүх ТЕЗ нар анхаарах нь зүйтэй байна.



Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

5.3. Шударга байдлын түвшний үнэлгээ

Яамдын ШБҮ 2019 онд дунджаар 73.2 болж, 4.3 пунктээр өсчээ. Нийт 13 яамнаас 1 яамны үнэлгээ өнгөрсөн оноос 3.5 пунктээр буурсан нь Гадаад харилцааны яам байна. Гадаад харилцааны яамны ШБҮ өмнөх оноос буурсан хэдий ч яамдын ШБҮ-ний дундаж онооноос 3.5 пунктээр өндөр байна. Үр дүнгээс харахад Зам, тээврийн хөгжлийн яамны үнэлгээ 0.1 пунктээр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үнэлгээнээс 0.3 пунктээр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам 3.5 пунктээр, Батлан хамгаалах яам 3.6 пунктээр өссөн байгаа нь бусад яамнаас харьцангуй бага өсөлттэй байна. Үр дүнгээс харахад яамдын ДШБҮ 82.0 болж 5.3 пунктээр өссөн байгаа нь яамдын авлигатай тэмцэх дотоод үйл ажиллагаа сайжирч байгааг илтгэж байна.

Яамдын ШБҮ, 2018, 2019 оныг харьцуулсан байдлаар:

№	Аймаг, нийслэл	2018	2019	Өөрчлөлт
1	Батлан хамгаалах яам	76.8	80.4	3.6
2	Гадаад харилцааны яам	80.2	76.7	(3.5)
3	Сангийн яам	67.1	75.5	8.4
4	Хууль зүй, дотоод хэргийн яам	66.2	73.6	7.4
5	Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	73.2	73.5	0.3
6	Эрчим хүчний яам	64.9	73.5	8.6
7	Барилга, хот байгуулалтын яам	68.0	73.2	5.2
8	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	66.1	71.9	5.8
9	Эрүүл мэндийн яам	66.3	71.5	5.2
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	66.8	70.9	4.1
11	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	67.1	70.6	3.5
12	Зам, тээврийн хөгжлийн яам	70.3	70.4	0.1
13	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	64.6	70.2	5.6
	Дундаж үнэлгээ	69.0	73.2	4.2




Захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан

5.4. Хэрэглэгчийн үнэлгээ

Боловсрол, спорт, соёл урлагийн салбарын үнэлгээ нь нийт салбарын дундаж үнэлгээнээс дээгүүр (3.26) үнэлэгдсэн. Тухайн салбарыг үнэлгээг гаргахдаа дараах асуултуудын үр дүнг ашигласан.

Боловсрол, спорт, соёл салбарын үнэлгээний дундаж:



Боловсрол, спорт, соёл урлагийн салбарын үнэлгээг гаргахад ашигласан асуултуудаас сургуулийн өмнөх боловсролтой холбоотой асуултыг иргэд хамгийн өндрөөр үнэлсэн. Харин "урлаг, соёлын үйлчилгээний хүртээмж", "нийтийн чөлөөт цагаа өнгөрөөх газар байгууламжийн хүртээмж" гэсэн үзүүлэлтүүдийг харьцангуй муу үнэлжээ.

Боловсрол, спорт, соёл урлагийн салбарын үнэлгээ нь судалгаанд оролцогчдын нийгмийн шинж байдлаас хамаарч ялгаатай байгаа эсэхийг дараах хүснэгтээс харж болно.

Боловсрол, спорт, соёл урлагийн салбарын үнэлгээнд оролцогчдын хүн ам зүйн байдлын үзүүлэх нөлөө:

Хүчин зүйлс	Ялгаатай эсэх	Тайлбар
Хотод эсвэл хөдөөд амьдрах байдал	Тийм	Улаанбаатар хотын иргэдийн үнэлгээ орон нутгийн иргэдээс мэдэгдэхүйц доогуур байна
Нас	Үгүй	Наснаас хамаарч ялгаатай хариулт өгөөгүй
Хүйс	Үгүй	Хүйсээс хамаарч ялгаатай хариулт өгөөгүй
Боловсрол	Тийм	Боловсролын түвшин өндөртэй иргэдийн үнэлгээ боловсролын түвшин багатай иргэдээс мэдэгдэхүйц доогуур байна
Орлого	Үгүй	Орлогоос хамаарч ялгаатай хариулт өгөөгүй

Иргэдийн Боловсрол, спорт, соёл урлагийн салбарыг үнэлж буй үнэлгээнд нас, хүйс, орлогоос хамаарсан ямар нэгэн ялгаатай байдал байгаагүй. Харин амьдарч буй бүс нутаг болон боловсролын хувьд ялгаатай байдал нь үнэлгээнд шууд нөлөөтэй байв.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

**ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭ БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БУЮУ
БИЕЛЭЛТ 76.9 ХУВЬТАЙ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН
ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

АУДИТЫН КОД: ГАГ-2020/01-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл
Утас: 263755, цахим хаяг: oyungerels@audit.gov.mn
Аудитын менежер З.Ариунзаяа
Утас: 261805, цахим хаяг: ariunzayaz@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Долгорсүрэн
Утас: 262451, цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn
Аудитор Ү.Төгсжаргал
Утас: 262451, цахим хаяг: tugsjargalu@audit.gov.mn
Аудитор М.Баяртогтох
Утас: 262451, цахим хаяг: bayartogtokhm@audit.gov.mn
Аудитор Б.Анхбаатар
Утас: 262451, цахим хаяг: ankhbaatar@audit.gov.mn

Улаанбаатар хот
2020 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилт үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Л.Оюун-Эрдэнэ/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/ нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т даалгасугай.

Д.ЗАНДАНБАТ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaal\2020\EA-In A Tushaal\0422GAG1.Docx

101010289

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	1
ЗУРАГ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	1
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	1
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ	2
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
БҮЛЭГ 1. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА	5
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХДӨӨ МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	5
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА	8
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ТООЦОО, СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА	9
БҮЛЭГ 2. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АХИЦ ГАРААГҮЙ БАЙНА	10
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНД НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДАЛ БУУРЧ, ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ДЭЭШИЛСЭН БАЙНА	10
ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	11
БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ ХАНГАЛТТАЙ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА	12
ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА	13
ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ ХАНГАЛТТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА	14
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН ШИЙДВЭРЛЭЭГҮЙГЭЭС ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖЭЭГҮЙ, ДУТУУ ХЭРЭГЖСЭН БАЙНА	14
ЗГХЭГ-ААС ХИЙСЭН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР ӨГСӨН ҮҮРГИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	15
АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ БҮРЭН ТАЙЛАГНААГҮЙ, ТУХАЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ЭСЭХ, ТӨСЛИЙН ТАЙЛБАР ҮНДЭСЛЭЛД ТУСГАСАН ЭСЭХИЙГ НЯГТЛАХГҮЙГЭЭР ҮНЭЛЖЭЭ	16
ЗГХЭГ-ААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР	19
ҮАГ-ЫН ТАЙЛБАР	22
САНГИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР	23
ҮАГ-ЫН ТАЙЛБАР	26
ДҮГНЭЛТ	27
ЗӨВЛӨМЖ	28
ХАВСРАЛТ 1. ХЭРЭГЖЭЭГҮЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА	29
ХАВСРАЛТ 2. ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА	30
ХАВСРАЛТ 3. ХЭРЭГЖИЛТ ДУТУУ АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА	31

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалахын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
НДС	Нийгмийн даатгалын сан
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

ЗУРАГ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Нэр
Дүрслэл 1	Үндсэн чиглэлийн арга хэмжээний бодлогын баримт бичигт нийцүүлсэн судалгаа
Дүрслэл 2	Нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл
Дүрслэл 3	Эдийн засгийн өсөлт
Дүрслэл 4	Инфляцын түвшин
Дүрслэл 5	Ажилгүйдлийн түвшин
Дүрслэл 6	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Нэр
Хүснэгт 1	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн судалгаа
Хүснэгт 2	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн санал, баталсан арга хэмжээний судалгаа
Хүснэгт 3	Яам, агентлагуудын саналд тусгагдаагүй, УИХ-аар хэлэлцүүлэх явцад нэмэгдсэн арга хэмжээний судалгаа
Хүснэгт 4	Санхүүжилтийн судалгаа
Хүснэгт 5	ЗГХЭГ-ын үнэлгээний судалгаа
Хүснэгт 6	Хэрэгжүүлэгч байгууллагуудын Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээний биелэлтийн судалгаа

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ**АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ:**

Аудитыг Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Төсвийн байнгын хорооны 2019 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хууль, журамд уялдуулан төлөвлөсөн эсэх,
- Хэрэгжүүлэгч яам, холбогдох байгууллагууд үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг үр нөлөөтэй хэрэгжүүлэн хууль, журмын дагуу биелэлт, үр дүнг тооцож, үнэлсэн эсэх

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ:

Аудитад УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төлөвлөгөөнд тусгагдсан 135 зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны 22 төв байгууллага, агентлагийг хамрууллаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитын явцад Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг баримтлан үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэгч яам, байгууллагын хариуцсан албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, тулган баталгаажуулах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль болон улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалт;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль;
- Улсын Их Хурлын 2018 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”;
- Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”;

- Засгийн Газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”;
- Засгийн Газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Засгийн Газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;
- “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн Газрын 2018 оны 294 дүгээр тогтоол;
- Засгийн Газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тодотгон батлах тухай” Засгийн Газрын 2019 оны 290 дүгээр тогтоол;
- Бусад хууль, эрх зүйн актууд.

ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ:

Дэлхийн хэмжээнд титэмт вирусн өвчлөл цар тахлын хэмжээнд хүрч, улсын хэмжээнд онцгой дэглэм тогтоосноор ихэнх байгууллагууд төвлөрөл үүсгэхгүй байх зорилгоор хорогдуулсан цаг болон онлайнаар ажиллах горимд шилжсэн тул яам, агентлаг дээр очиж ажиллах боломжгүй болж, аудитын явцад дараах хүндрэлүүд тулгарлаа. Үүнд:

- Яам, агентлагуудын үндсэн чиглэл хариуцсан болон бусад мэргэжилтнээс шаардлагатай баримт материалыг шуурхай авах боломжгүй болох,
- Тайлбар тодруулга авах, асууж лавлах асуудлыг утсаар холбогдон авахад хугацаа алдах.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын 2018 оны 37 дугаар тогтоолоор “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль, бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн Газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллагад, биелэлтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж, танилцуулахыг Засгийн газарт тус тус үүрэг болгосон байна.

Улсын Их Хурлаас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д дараах 5 бодлого, 20 зорилтын хүрээнд 135 арга хэмжээг төрийн захиргааны 22 төв байгууллага, агентлаг хэрэгжүүлэхээр баталжээ.

Хүснэгт № 1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн судалгаа

№	Бодлого	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Санхүүжилтийн эх үүсвэр (тэрбум төгрөгөөр)				
				улсын төсөв	гадаад эх үүсвэр	хувийн хэвшил	сан, бусад	нийт дүн
	НИЙТ ДҮН	20	135	899.7	2,360.6	4,815.9	649.1	8,725.3
1	Макро эдийн засгийн бодлого	2	9					-
2	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	5	34	131.0	1,493.1	4,586.7	319.2	6,530.0
3	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	3	21	158.9	796.4	229.2	249.3	1,433.8
4	Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	6	49	564.2	20.1		77.7	662.0
5	Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	4	22	45.6	51.0		2.9	99.5

Эх сурвалж: УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 135 арга хэмжээг улсын төсвийн 899.7 тэрбум, гадаад эх үүсвэрийн 2,360.6 тэрбум, хувийн хэвшлийн 4,815.9 тэрбум, Хөгжлийн банкны санхүүжилт болон тусгай сан, бусад эх үүсвэрийн 649.1 тэрбум нийт 8,725.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 6,130.5 тэрбум төгрөг буюу нийт төлөвлөсөн хөрөнгийн 70.3 хувийг зарцуулсан байна.

БҮЛЭГ 1. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХДӨӨ МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

1.1. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3¹ дахь заалтыг үндэслэн нийт 304 арга хэмжээг 23,396.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх саналыг Сангийн яаманд ирүүлсэн байна.

1.2. Үндэсний хөгжлийн газар Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар санал, дүгнэлт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасныг үндэслэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд санал боловсруулж, хүргүүлсэн боловч Сангийн яам зарим саналыг тусгаагүй байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 48.2² дахь заалтын дагуу үндсэн чиглэлд тусгасан 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй арга хэмжээнүүдийг Сангийн яам, Үндэсний хөгжлийн газрын хамтарсан ажлын хэсгийн боловсруулсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулах;
- Нэр бүхий зарим томоохон төсөл арга хэмжээний 2019 онд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг эцэслэн шийдвэрлэсэн эсэхийг дахин нягтлах;
- (2.7) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг 50 хувь болгон бууруулах.

1.3. Сангийн яам Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгах саналыг нэгтгэн боловсруулж, 5 бодлого, 20 зорилтын хүрээнд 122 арга хэмжээг 8,471.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, саналыг Засгийн газарт хүргүүлснийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7³ дахь заалтыг үндэслэн хянан хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлжээ.

1.4. Засгийн газраас өргөн мэдүүлсэн үндсэн чиглэлийн саналыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8⁴-д заасны дагуу хэлэлцэж, УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор 5 бодлого, 20 зорилтын хүрээнд 135 арга хэмжээг 8,725.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 13 яам, 9 агентлаг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн санал, баталсан арга хэмжээний судалгаа

(тэрбум төгрөгөөр)

Бодлого	Зорилт	Санал		Баталсан		Нэмсэн арга хэмжээний тоо	санхүүжилт	
		арга хэмжээ	санхүүжилт	арга хэмжээ	санхүүжилт		нэмсэн	хассан
Макро эдийн засгийн бодлого	1	2	-	2	-	-	-	-
	2	7	-	7	-	-	-	-
	дүн	9	-	9	-	-	-	-
	3	4	87.7	4	87.7	-	-	-

¹ Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

² энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 1-д заасны дагуу арга хэмжээ бүрд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр нь үндэслэлтэй, бодитой, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх.

³ Засгийн газар улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хянан хэлэлцэж, жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

⁴ Улсын Их Хурал Засгийн газраас өргөн мэдүүлсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэн батална.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	4	10	594.6	10	761.9	-	167.3	
	5	4	3,892.6	5	3,725.8	1		166.8
	6	9	837.0	9	838.4	-	1.4	
	7	6	1,161.1	6	1,116.1	-		45.0
	дүн	33	6,573.0	34	6,530.0	1	168.7	211.8
Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	8	8	744.6	8	1,013.9	-	269.3	
	9	7	222.8	10	330.6	3	107.8	
	10	3	89.3	3	89.3	-	-	-
	дүн	18	1,056.7	21	1,433.8	3	377.1	-
Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	11	7	274.4	7	249.9	-		24.5
	12	2	1.0	4	36.0	2	35.0	
	13	3	6.8	4	14.0	1	7.2	
	14	7	6.5	7	6.5	-	-	-
	15	5	54.6	7	117.8	2	63.2	
	16	18	419.2	20	237.8	2		181.4
	дүн	42	762.5	49	662.0	7	105.4	205.9
Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	17	7	72.8	9	92.8	2	20.0	
	18	4	0.1	4	0.1	-	-	-
	19	4	0.3	4	0.3	-	-	-
	20	5	6.3	5	6.3	-	-	0.0
	дүн	20	79.5	22	99.5	2	20.0	0.0
НИЙТ ДҮН		122	8,471.8	135	8,725.3	13	671.2	417.7

Эх сурвалж: Сангийн яам, ЗГХЭГ-ын санал, УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"

1.5. УИХ-аар "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн төслийг хэлэлцэх явцад санхүүжилтийн эх үүсвэрийг 671.2 тэрбум төгрөгөөр нэмж, 417.7 тэрбум төгрөгөөр хасч, 15 арга хэмжээг нэмж, 2 арга хэмжээг хасч баталсан байна.

1.6. Ингэхдээ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан "судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх" зарчмыг баримтлахгүйгээр яам, агентлагуудын саналд тусгагдаагүй, тооцоо судалгаагүй дараах арга хэмжээг нэмж баталжээ.

Хүснэгт 3. Яам, агентлагуудын саналд тусгагдаагүй, УИХ-аар хэлэлцүүлэх явцад нэмэгдсэн арга хэмжээний судалгаа

№	Бодлогын баримтын дугаар	Арга хэмжээ	Санхүүжих дүн (тэрбум төгрөгөөр)
1	2.7	Зээлийн хүүг бууруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг эрчимжүүлэх	
2	5.5	Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөнөөр болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулан, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны эзлэх хувийг нэмэгдүүлэх	
3	9.3	Цаг уур, орчны шинжилгээний техник технологийн шинэчлэл, сүлжээний өргөтгөл хийх	10.0
4	9.9	Байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тогтоох үнэлгээнд орон нутаг оролцдог байх, санхүүжилтийг төсөвт тусгах	
5	9.10	Цөлжилт доройтлыг бууруулах	
6	11.7	Багш нарын цалин, урамшууллыг нэмэх	33.2
7	12.3	Соёл, урлаг, шинжлэх ухааны салбарын ажиллагсдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	1.2
8	12.4	2020 онд Герман болон Европын бусад орнуудад Чингис хааны өмнөх болон дараах үеийн түүх археологийн үзэсгэлэн гаргах бэлтгэл ажиллагааг хангах	
9	13.4	Шинжлэх ухаан технологи, инновацын салбарт олон улсын жишигт нийцсэн барилга байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох	7.2
10	15.6	Халдварт сүрьеэ өвчнийг илрүүлэх, оношлох, эмчлэх	0.5
11	15.7	Сүрьеэгийн эмнэлгийн барилга шинээр барих/360 ортой	10.0
12	16.8	Ядуу хүн амын эрэлт хэрэгцээнд тохирсон халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээг бүлэг тус бүрд ялгавартайгаар хүргэх	
13	16.20	Багш, эмч нарын цалин, хөлсний менежментийг боловсронгуй болгох замаар үе шаттайгаар цалин, хөлсийг нэмэгдүүлэх	
14	17.9	Хууль сахиулах их сургуулийн спорт цогцолбор, номын сангийн барилгыг барих	20.0
15	17.8	Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийг нэмэгдүүлэх	
		Дүн	82.1

Эх сурвалж: Сангийн яам, ЗГХЭГ-ын санал, УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"

1.7. УИХ-аар үндсэн чиглэлийг хэлэлцэх явцад нэмсэн дээр дурдсан 15 арга хэмжээний 10.0 тэрбум төгрөгийн 3 арга хэмжээ хэрэгжээгүй, 17.2 тэрбум төгрөгийн 5 арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. Тухайлбал:

Хэрэгжээгүй арга хэмжээ:


- (9.10) Цөлжилт, газрын доройтлыг бууруулах аргачлалыг шинэчлэх;
- (15.7) Сурьээгийн эмнэлгийн 360 ортой 10.0 тэрбум төгрөгийн санхүүжилттэй барилгыг шинээр барих ажлыг 50 хувьд хүргэх;
- 16.8) Ядуу хүн амын эрэлт хэрэгцээнд тохирсон халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээг бүлэг тус бүрд ялгавартайгаар хүргэх.

Дутуу хэрэгжсэн арга хэмжээ:

- (2.7) Зээлийн хүүг бууруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- 5.5) Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөнөөр болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулан, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны эзлэх хувийг нэмэгдүүлэх;
- (9.3) Цаг уур, орчны шинжилгээний техник технологийн шинэчлэл, сүлжээний өргөтгөл хийх;
- (12.4) 2020 онд Герман болон Европын бусад орнуудад Чингис хааны өмнөх болон дараах үеийн түүх археологийн үзэсгэлэн гаргах бэлтгэл ажиллагааг хангах;
- (13.4) Шинэслэх ухаан технологи, инновацын салбарт олон улсын жишигт нийцсэн барилга байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох.

1.8. Аудитаар үндсэн чиглэлийн арга хэмжээг Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн төлөвлөсөн эсэхэд судалгаа, шинжилгээ хийлгэх зорилгоор зөвлөх ажиллууллаа.

Дүрслэл 1. Үндсэн чиглэлийн арга хэмжээний бодлогын баримт бичигт нийцүүлэн судалгаа



1.9. Зөвлөхийн судалгааны тайланд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 135 арга хэмжээг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн боловсруулсан боловч зарим бодлогын уялдааг хангахгүйгээр төлөвлөсөн байна гэж дурджээ. Тухайлбал:

- Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д 20 хувьд хүргэх, Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогод 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувьд хүргэхээр тус тус заасан боловч сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх стратеги тодорхойгүй, тус салбарын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах талаарх бодлого боловсрол, мэргэжлийн боловсролын байгууллагад төлөвлөгдөөгүй, мэдээлэл хангалтгүй байна.
- Монгол Улсад ажиллах хүчний оролцооны түвшин 1992 онд 75.8 хувь хүрсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бөгөөд 2010 оноос эхлэн тасралтгүй буурч 61.6 хувиас нэмэгдээгүй байхад Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын 2.2.1-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, 2016-2020 онд хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинийг 6 хувьд хүргэх, ... зорилтыг дэвшүүлсэн боловч ажиллах хүчний гадагшаа чиглэсэн урсгал, гаднаас оруулахгүй байх бодлогын зөрүүгээс тухайн зорилт биелэх боломжгүй байна. Мөн хөрөнгө оруулалтын томоохон төсөл, арга хэмжээг дагаж хичнээн хүний нөөц шаардлагатай байгаа талаарх нарийн тооцоолол байхгүй байгаа нь дотоод ажлын байрыг хадгалах, залуучуудыг тогтоон ажиллуулах боломжийг хязгаарлаж, ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд орох нөхцөлийг бий болгож байна.
- Үндсэн чиглэлийн 2.6.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг Гурван тулгуурт хөгжлийн бодлоготой, 2.7.Зээлийн хүүг бууруулах санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг эрчимжүүлэх зэрэг арга хэмжээг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-тай буюу дан ганц хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулсан нь салбарын яам, агентлагуудын хэрэгжүүлж буй төслүүдтэй хэрхэн уялдсан, үр нөлөө нь хэрхэн илэрхийлэгдэх нь тодорхойгүй, ямар нэгэн зорилгод хүрэх арга хэрэгсэл төдий зүйл болсон байна.

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

1.10. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн арга хэмжээг Засгийн Газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого боловсруулах нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтаар төлөвлөсөн боловч тухайн жилд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хүрэх түвшнийг тодорхой тусгаагүй, хэрэгжих боломжтой хугацааг үндэслэлтэй тооцож төлөвлөөгүй, шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоогоогүй, судалгаа шинжилгээнд үндэслэхгүйгээр хэт ерөнхий байдлаар тусгажээ. Тухайлбал:

ХХААХҮЯ:

- (3.2) Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийх, мал аж ахуйн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, түүний техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх арга хэмжээний хүрээнд мэдээллийн онлайн системийг бүрдүүлж, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлд 339 сум, дүүргийг хамруулахаар баталсан боловч улсын хэмжээний мэдээллийн сан бүрдүүлэхэд зарцуулах хугацаа, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөөгүй.
- (4.5) Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг 30 хувьд хүргэхээр төлөвлөсөн нь тайлант онд хэдэн үйлдвэр ашиглалтад оруулах, орон нутгийн онцлогт уялдуулан үндэсний үйлдвэрийн аль салбарыг хөгжүүлэхийг тодорхой тусгаагүй;
- (4.9) Төрөөс, дотоодын худалдан авалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг тодорхойлохдоо дотоодын худалдан авалтыг 10 хувиар өсгөхөөр төлөвлөсөн боловч санхүүжилтийн эх үүсвэрийг батлаагүй, төрөөс дотоодын худалдан авалтын хэдэн нэр төрлийн бүтээгдэхүүнийг дэмжих талаар тодорхой бус.

БХБЯ:

- (8.8) Ган төмөрлөг болон цементийн үйлдвэрлэлийг дэмжих, бизнесийн таатай орчныг бий болгох арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэхээр баталсан боловч тус арга хэмжээний хүрээнд хийх ажлыг тодорхой тусгаагүй.

БОАЖЯ:

- (9.3) Бүгд Найрамдах Солонгос Улсын Экзим банкны 15.9 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр Байгаль орчны төв лабораторийн барилгын ажлыг 100 хувь хэрэгжүүлэхээр баталсан боловч тайлант онд зөвхөн урьдчилсан судалгааны ажил хийгдсэн.

ХЗДХЯ:

- (17.5) Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын материалаар хангах арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэхээр баталсан боловч шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгаагүй;
- (17.6) Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, хүртээмжтэй шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, улсын бүртгэлийн цогцолбор байгуулах арга хэмжээний хүрээнд “Нэг иргэн-нэг бүртгэл” хөтөлбөрийн хэрэгжилтийг 20 хувьд хүргэхээр баталсан нь хүрэх түвшнийг оновчтой тогтоогоогүй.

ХНХЯ:

- (16.1) Зохион байгуулалттай болон хүний ур чадварт түшиглэсэн 45.0 мянгаас доошгүй ажлын байр бий болгох, 60.0 мянган хүнийг төсөл, хөтөлбөрт хамруулахаар баталсан нь хүрэх түвшнийг холбогдох үндэслэл, тооцоогүйгээр тусгасан;
- (16.2) “Гэрээт малчин” төсөл хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийг ажилтай, орлоготой болгох арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг төсөлд хамрагдах малчин өрхийн тоогоор тогтоосон нь хүрэх түвшинтэй уялдаагүй байна.

1.11. Энэ нь үндсэн чиглэлийн арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн холбогдох заалт, зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгасан байна” гэсэн заалтад нийцүүлэхгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

1.12. Үндсэн чиглэлийн арга хэмжээг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, салбарын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн боловч зарим арга хэмжээг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүйгээс хүрэх түвшнийг тодорхой тусгаагүй, хэрэгжих боломжтой хугацааг үндэслэлтэй тооцож төлөвлөөгүй, шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоогоогүй, хэт ерөнхий байдлаар төлөвлөсөн зөрчил жил бүр давтагдсаар байна.

ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ТООЦОО, СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

1.13. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээг 11,589.8 тэрбум төгрөгөөр, “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаар батлах тухай” Засгийн Газрын 2018 оны 191 дүгээр тогтоолоор хэрэгжүүлэгч байгууллагуудын 2019 оны урсгал зардлыг 4,213.8 тэрбум төгрөгөөр тус тус баталжээ.

1.14. УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д 74 арга хэмжээг улсын төсвийн 899.7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр баталсан нь 2019 оны нэгдсэн төсвийн зарлагын 7.8 хувийг, урсгал зардлын 21.3 хувийг тус тус эзэлж байна.

1.15. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9-д “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна” гэж заасантай нийцүүлэн тухайн жилийн төсвийн хязгаар, төсвийн төслийг төлөвлөөгүйгээс шалтгаалжээ.

1.16. Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 48.2-т “энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 1-д заасны дагуу арга хэмжээ бүрд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр нь үндэслэлтэй, бодитой, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх” гэсэн заалтад нийцүүлэн дараах арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөөгүй байна. Тухайлбал:

БОАЖЯ:

- (9.4) Гидрогеологийн дунд масштабын зураглал, хайгуул судалгааны 3 ажил, сүлжсээнд холбогдсон усны хяналт-шинжилгээний 50 харуул бий болгох ажлыг улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр баталсан боловч санхүүжилт батлаагүйгээс төслийн хөрөнгөөр санхүүжүүлсэн.

ХХААХҮЯ:

- (4.7) Жижиг, дунд үйлдвэрийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд 400-аас доошгүй төслийг улсын төсөв, гадаад эх үүсвэрийн 200.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан боловч улсын төсвөөс 47.0 тэрбум төгрөгийн зээлийг 451 төсөлд олгосон.

БСШУСЯ:

- (11.2.4) Аюулгүй загвар орчныг ерөнхий боловсролын 652 сургуульд бүрдүүлэх арга хэмжээг улсын төсвийн 0.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр баталсан боловч дотоод нөөц хөрөнгөөр гүйцэтгэсэн.


1.17. Баталсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц санхүүжилтийг тооцоо судалгаанд үндэслэн бодитой тооцож, төлөвлөөгүйгээс санхүүжилтийн эх үүсвэргүй болох, дутагдах зэрэг нөхцөл байдал бий болсноос арга хэмжээ хэрэгжихгүй, дутуу хэрэгжих үр дагавар үүсч байна.

БҮЛЭГ 2. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АХИЦ ГАРААГҮЙ БАЙНА

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНД НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДАЛ БУУРЧ, ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ДЭЭШИЛСЭН БАЙНА

2.1. Эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг дээшлүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн эрсдэл даах чадавхыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах 2 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 6 нь дутуу, 3 нь бүрэн хэрэгжсэн бөгөөд хэрэгжилт 80.0 хувьтай байна.

Дүрслэл 2. Нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл (тэрбум төгрөгөөр)



2.2. Нэгдсэн төсвийн 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 627.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-д баталсан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлээс 1,285.5 тэрбум төгрөгөөр бага байгаа нь төсвийн алдагдлыг бууруулах зорилготой нийцэж байна.

Эх сурвалж: ҮСХ-ноос гаргасан “Монгол Улсын 2019 оны нийгэм, эдийн засгийн байдал”

2.3. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа 2019 оны урьдчилан гүйцэтгэлээр 57.0 хувьтай гарч, зорилтот түвшнээс 1.7 нэгж хувиар илүү байгаа боловч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4⁵-т заасан шаардлагад нийцэж байна.

2.4. Инфляцын түвшин 2019 оны эцэст 5.2 хувьтай байгаа нь зорилтот түвшнээс 3.2 нэгж хувиар бага, өмнөх оноос 2.9 нэгж хувиар буурчээ. Инфляцын өсөлтөд хүнсний бараа, ус, ундаа, мах, махан бүтээгдэхүүн, хувцас, бөс бараа, боловсролын үйлчилгээний бүлэг болон импортын барааны үнийн өсөлт тус тус нөлөөлсөн байна.

Дүрслэл 3. Инфляцийн түвшин (хувиар)




Эх сурвалж: ҮСХ-ноос гаргасан “Монгол Улсын 2019 оны нийгэм, эдийн засгийн байдал”

⁵ Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.

2.5. Монголбанк 2019 онд нийт 15.2 тонн алт худалдан авч, гадаад валютын албан нөөц 4,348.6 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 22.5 хувиар буюу 799.0 сая ам.доллараар өсөж, импортын 9 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрчээ.

Дүрслэл 4. Эдийн засгийн өсөлт, хувиар




Эх сурвалж: ҮСХ-ноос гаргасан "Монгол Улсын 2019 оны нийгэм, эдийн засгийн байдал"

2.6. Тайлант онд эдийн засгийн өсөлтийг 8.0 хувьд хүргэхээр төлөвлөсөн боловч 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5.1 хувьтай гарч, өмнөх оноос 2.1 нэгж хувиар буурсан нь мөнгөний бодлогын хүрээнд өрхийн өрийн дарамтыг багасгах зорилгоор цалингийн болон тэтгэврийн зээлийг хязгаарласнаас нийт зээлийн өсөлт, уул уурхайн салбарын эдийн засгийн өсөлт тус тус буурсантай холбоотой байна.

2.7. ҮСХ-ноос гаргасан ажиллах хүчний түүвэр судалгаагаар 2019 оны жилийн эцэст ажиллах хүчний оролцооны түвшин 60.7 хувьтай байгаа нь зорилтот түвшнээс 3.3 нэгж хувиар бага, ажилгүйдлийн түвшин 8.1 хувьтай байгаа нь зорилтот түвшнээс 0.6 нэгж хувиар илүү байна.

Дүрслэл 5. Ажилгүйдлийн түвшин (хувиар)



Эх сурвалж: ҮСХ-ноос гаргасан "Монгол Улсын 2019 оны нийгэм, эдийн засгийн байдал"

2.8. Зарим арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй, хэрэгжүүлэгч, яам, агентлагуудын үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс дараах арга хэмжээний хэрэгжилт хүрэх түвшнийг хангаагүй байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас үзнэ үү) Тухайлбал:

Монголбанк:

- (2.2) Валютын орох урсгал өндөр үед гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх;
- (2.5) Банк, санхүүгийн тогтолцооны эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх;
- (2.7) Зээлийн хүүг бууруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг эрчимжүүлэх.

СЗХ:

- (2.4) Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин, дэд бүтцийг боловсронгуй болгож, бизнес эрхлэгчдэд хямд өртөгтэй санхүүжилт татах боломжийг бүрдүүлэх.

ХНХЯ:

- (1.2) Зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэж, хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

2.9. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг дэмжиж, хүнсний эрүүл ахуйн чанарыг сайжруулах, геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд

чиглэсэн тээврийн салбарыг хөгжүүлэх зэрэг 5 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 5 нь хэрэгжээгүй, 6 нь эрчимжүүлэх шаардлагатай, 16 нь дутуу, 7 нь хэрэгжсэн бөгөөд хэрэгжилт 60.6 хувьтай байна.

2.10. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдээгүй, бэлтгэл ажлыг бүрэн хангаагүй, хүрэх түвшнийг оновчтой тогтоогоогүйгээс дараах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү) Тухайлбал:

ХХААХҮЯ:

- (4.3) Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах барилгын ажлыг 80 хувьд хүргэх;
- (4.8) Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн парк байгуулах ажлыг 30 хувьд хүргэх.

УУХҮЯ:

- (5.4) Хунд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх.

ЭХЯ:

- (6.2) Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, Өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих.

ЗТХЯ:

- (7.6) Орон нутгийн нисэх буудлуудын чадавхыг дээшлүүлэх.

2.11. Үндсэн чиглэлд баталсан арга хэмжээний хүрэх түвшнийг бодитой тооцоолж төлөвлөөгүйгээс дараах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос үзнэ үү) Тухайлбал:

ХХААХҮЯ:

- (3.2) Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийх, мал аж ахуйн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, түүний техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх;
- (4.5) "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлэх.

ЭХЯ:

- (6.3) Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлэх;
- (6.4) Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх;
- (6.6) Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөл, эрчим хүчээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- (6.8) Метан хийг ашиглах боломжит нөөцийг бүрдүүлэх судалгааг эрчимжүүлэх, хийн хангамжийг хөгжүүлэх эрх зүй, дэд бүтцийн орчныг бүрдүүлэх, нүүрснээс цэвэр түлш гарган авах үйлдвэр барих төслийг эхлүүлэх.

БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ ХАНГАЛТТАЙ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

2.12. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах, агаарын бохирдлыг бууруулан байгалийн нөөцийн хамгаалалт, зохистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүний чадавхыг сайжруулж, гамшгийн үеийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх зэрэг 3 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 1 нь хэрэгжээгүй, 3 нь эрчимжүүлэх шаардлагатай, 7 нь дутуу, 10 нь бүрэн хэрэгжсэн бөгөөд хэрэгжилт 76.7 хувьтай байна.

2.13. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдээгүй, хүрэх түвшнийг бодитой тооцоолж төлөвлөөгүй, худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон, гэрээ, хэлэлцээр удааширсан, хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй зэргээс шалтгаалан дараах арга хэмжээнүүд дутуу хэрэгжсэн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос үзнэ үү) Тухайлбал:

БХБЯ:

- (8.4) Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих болон өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх.

БОАЖЯ:

- (9.3) Цаг уур, орчны шинжилгээний техник, технологийн шинэчлэл, сүлжээний өргөтгөл хийх арга хэмжээний хүрээнд Байгаль орчны төв лабораторийн барилга барих.

ОБЕГ:

- (10.3) Гамигийн үед ашиглах нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах механикжсан хүнсний болон шатахууны агуулах барих.

ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА

2.14. Боловсролын болон соёл, урлаг, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацыг хөгжүүлэн шинжлэх ухаан, харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйл ажиллагааг өргөжүүлэх, төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, шуурхай байдлыг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг 6 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 7 нь хэрэгжээгүй, 7 нь дутуу, 35 нь бүрэн хэрэгжиж, 83.5 хувийн хэрэгжилттэй байна.

2.15. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа оройтож зарлагдсанаас шалтгаалан (15.7) Сүрьеэгийн эмнэлгийн 360 ортой барилгыг улсын төсвийн 10.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барих ажлыг 50 хувьд хүргэх арга хэмжээ хэрэгжээгүй байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү)

2.16. Хэрэгжүүлэгч яамны үйл ажиллагаанаас хамаарахгүйгээр санхүүжилтийг улсын төсөвт батлаагүй, хүрэх түвшнийг оновчтой тогтоогоогүйгээс шалтгаалан дараах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү) Тухайлбал:

ХНХЯ:

- (16.8) Ядуу хүн амын эрэлт хэрэгцээнд тохирсон халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээг бүлэг тус бүрд ялгавартайгаар хүргэх арга хэмжээний хүрээнд 16.0 мянгаас доошгүй өрхийг ядуурлаас гаргахаар төлөвлөсөн боловч тогтоосон шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй;
- (16.10) Хүүхэд төрүүлсэн эхэд даатгуулсан хэлбэрээс үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сайн дураар даатгуулсан эхэд дундаж цалингаас тэтгэмж авах арга хэмжээг НДС-ын 4.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 100 хувь хэрэгжүүлэх;
- (16.11) Төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан 1 жилийг 1.5 жилээр тооцох хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг НДС-ын 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 100 хувь хэрэгжүүлэх;
- (16.12) 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүдийн нийгмийн даатгалын илтгэл төлсөн хугацааг тасрахгүй байх нөхцөл бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд улсын төсвийн 16.0 тэрбум төгрөг, НДС-ын 3.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж, 50.0 мянгаас доошгүй эхчүүдийг хамруулах;
- (16.17) Төр, хувийн хэвшил, олон нийтийн дэмжлэгтэйгээр ахмад настны эрх, хөгжил, хамгааллыг сайжруулж, нийгмийн харилцаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хөтөлбөрийн 30 хувьд хүргэхээр төлөвлөсөн боловч Засгийн газрын 2019 оны 389 дүгээр тогтоолоор "Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийг баталж, хэрэгжүүлэх хугацааг 2020 оноос эхлэхээр тогтоолд тусгасан.

2.17. Үндсэн чиглэлд баталсан арга хэмжээний хүрэх түвшнийг бодитой тооцоолж төлөвлөөгүйгээс дараах арга хэмжээнүүд дутуу хэрэгжсэн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас үзнэ үү) Тухайлбал:

БСШУСЯ:

- (11.4) Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгох;
- (11.4) 2020 онд Герман болон Европын бусад орнуудад Чингис хааны өмнөх болон дараах үеийн түүх, археологийн үзэсгэлэн гаргах бэлтгэл ажиллагааг хангах;
- (13.4) Шинжлэх ухаан технологи, инновацын салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох.

ЭМЯ:

- (15.2.2) Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээний хүрээнд эрт илрүүлэх үзлэгийг 10 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн боловч улсын хэмжээнд жилийн эцэст нийт 153.3 мянган хүн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан нь артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг 5.7 хувиар, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг 5.3 хувиар, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг 6 хувиар, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг 1.2 хувиар тус тус өссөн;
- (15.2.3) Харвалт, шигдээсний нэгжсийг 2 эмнэлэгт байгуулахаар төлөвлөсөн боловч Үндэсний оношилгоо, эмчилгээний төвд 1 нэгжсийг байгуулсан;
- (15.3.2) Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт, сэргийлэлтийг сайжруулж, өвчний тохиолдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд вирус гепатит В, С вирусийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээнд 15-65 насны хүн амын 90 хувийг хамруулахаар төлөвлөсөн боловч 67.4 хувь буюу 1.0 сая хүн хамрагдсан;
- (15.5.2) Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж үйлчилгээнээс үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд шинээр хоёрдугаар шатлалын 5 нэгдсэн эмнэлэг, 2 өргөтгөлийг байгуулахаар төлөвлөсөн боловч 4 нэгдсэн эмнэлэг, 1 эмнэлгийн барилгын өргөтгөл ашиглалтад орсон;

- (15.5.3) Шинээр гуравдугаар шатлалын 4 эмнэлгийн ашиглалтад оруулахаар төлөвлөсөн боловч Улаанбаатар хотын Хан-уул дүүрэгт баригдаж буй 300 ортой төрөх эмнэлэг 85 хувийн гүйцэтгэлтэй, Геронтологийн төвийн барилга 45 хувийн гүйцэтгэлтэй байна.

ХНХЯ:

- (16.1) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд зохион байгуулалттай болон хувь хүний ур чадварт түшиглэсэн ажлын байр бий болгох арга хэмжээний хүрээнд 45.0 мянгаас доошгүй ажлын байр бий болгохоор төлөвлөсөн боловч оны эцсийн байдлаар түр болон байнгын 32.0 мянган ажлын байр бий болгосон байна.

ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ ХАНГАЛТТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА

2.18. Хууль тогтоомжийг боловсронгуй болгож, төрийн албаны тухай хуулийг сурталчлах, төрийн болон орон нутгийн өмчийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, стандарт хэмжил зүйн байгууллагын олон улсын итгэмжлэлийн үйл ажиллагааг сайжруулах, хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх зэрэг 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2 нь эрчимжүүлэх шаардлагатай, 6 нь дутуу, 14 нь бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт 86.4 хувьтай байна.

2.19. Хүрэх түвшнийг бодитой тооцоолж төлөвлөөгүй, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдээгүйгээс дараах арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос үзнэ үү) Тухайлбал:

ХЗДХЯ:

- (17.1) Шүүхийн шинэжилгээний тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

СХЗГ:

- (18.2) Улсын эталоны нарийвчлалын түвшнийг дээшлүүлж, баталгаажуулалтын болон эталон лабораторийг байгуулах.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН ШИЙДВЭРЛЭЭГҮЙГЭЭС ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖЭЭГҮЙ, ДУТУУ ХЭРЭГЖСЭН БАЙНА

2.20. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д 135 арга хэмжээг нийт 8,725.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр баталснаас 6,130.5 тэрбум төгрөг буюу төлөвлөсөн санхүүжилтийн 70.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4. Санхүүжилтийн судалгаа
(тэрбум төгрөгөөр)

Санхүүжилтийн эх үүсвэр	төлөвлөгөө	гүйцэтгэл
Улсын төсөв	899.7	1,018.1
Гадаад эх үүсвэр	2,360.6	932.1
Хувийн хэвшил, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	4,815.9	3,507.8
Хөгжлийн банк, тусгай зориулалтын сан бусад	649.1	672.5
Нийт дүн	8,725.3	6,130.5

Эх сурвалж: Сангийн яамны тайлан

2.21. Хэрэгжүүлэгч яам, агентлагууд Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журамд заасны дагуу зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр, мөнгөн дүнг хэрэгжилтийн тайланд бүрэн тусгаагүйгээс санхүүжилтийн гүйцэтгэлийг бодитой гаргах боломжгүй байгаа тул Сангийн яамнаас ирүүлсэн дүнгээр аудитын тайланд тусгалаа.

2.22. Гадаад эх үүсвэр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байхад зарим арга хэмжээний хүрэх түвшнийг хэрэгжих боломжтой хугацаагаар тооцож төлөвлөөгүйгээс дараах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Тухайлбал:

ЭХЯ:

- (6.2.4) Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх төслийн гэрээ, хэлэлцээрийн ажлыг 100 хувьд хүргэх;
- (6.2.5) Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ-г боловсруулж, хүчин чадлыг өргөтгөх төслийн гэрээ, хэлэлцээрийн ажлыг 100 хувь хэрэгжүүлэх;

- (6.5.2) Төр хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгөөр Багануур дэд станцаас Чойр хүртэл 220 кВ-ын 2 хэлхээт 178 км ЦДАШ болон дэд станц барих төслийн гэрээ, хэлэлцээр хийх ажлын явцыг 100 хувьд хүргэх.

ЗТХЯ:

- (6.1) Орон нутгийн нисэх буудлуудын чадавх дээшлүүлэх зорилтын хүрээнд Ховд, Өмнөговь аймгийн нисэх буудлуудыг өргөтгөн шинэчлэх барилгын ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж, 40 хувьд хүргэх;
- (7.3) Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан авто замын сүлжээг сайжруулах, түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээ авах зорилтын хүрээнд Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 30 хувьд хүргэх, Тусгай замын автобус (BRT) системийг нэвтрүүлэх 1 дүгээр шатны барилгын ажлыг 36.0 тэрбум төгрөгийн гадаад эх үүсвэрээр хэрэгжүүлж, 50 хувьд хүргэх.

ХХААХҮЯ:

- (4.2.1) Хүн амыг эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнээр хангах зорилтын хүрээнд улсын төсвийн 5.0 тэрбум, гадаад эх үүсвэрээр хэрэгжүүлж, өвөл, зуны хүлэмжийн талбайг 10 га-аар нэмэгдүүлэх.

2.23. Гадаад эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн томоохон төслүүдийн хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч, гүйцэтгэгч талтай хийх гэрээ, хэлцэл удааширснаас дараах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Тухайлбал:

ХХААХҮЯ:

- (4.4.3) Аялагдсан бүс нутагт элеватор шинээр байгуулах ажлыг 80 хувьд хүргэх.

ЭХЯ:

- (6.1.3) Гуравдугаар ДЦС-ыг 250 МВт-аар өргөтгөх барилгын ажлын явцыг 30 хувьд хүргэх;
- (6.2.1) Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц барих төслийн санхүүгийн хаалт хийх;
- (6.2.3) Баруун бүсийн 60 МВт-ын ДЦС-ын барилгын ажлыг 20 хувьд хүргэх.

БХБЯ:

- (8.4.3) Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр барих барилгын ажлыг 30 хувьд хүргэх.

2.24. Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим арга хэмжээний санхүүжилтийг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд батлаагүйгээс дараах арга хэмжээнүүд хэрэгжээгүй, дутуу хэрэгжсэн байна. Тухайлбал:

Хэрэгжээгүй арга хэмжээнүүд:

БХБЯ:

- (8.2.4) Улсын хэмжээнд 681 цэгт өндрийн II ангийн сүлжээний давтан хэмжилт, хайгуул судалгаа хийх ажлыг улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэх.

ЭХЯ:

- (6.5.5) 220 кВ-ын Дархан дэд станцын барилгын ажлыг улсын төсвийн 5.0 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлж, 20 хувьд хүргэх.

ОБЕГ:

- (10.3) Гамигийн үед ашиглах нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах механикжсан хүнсний болон шатахууны агуулахыг барих.

Дутуу хэрэгжсэн арга хэмжээнүүд:

БХБЯ:

- (8.2.2) Монгол Улсын 15 байришлд GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг улсын төсвийн 0.6 тэрбум төгрөгөөр барих;
- (8.2.3) Газар зүйн 350 мянган нэрийн тодруулга, солбицолжуулалтыг нийт газар нутгийн 30 хувьд хүргэх.

БСШУСЯ:

- (11.2.2) Ерөнхий боловсролын сурагчдын аюулгүй, ая тухтай сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилтын хүрээнд шинээр Ерөнхий боловсролын 62 сургуулийг ашиглалтад оруулах;
- (13.4) Шинжлэх ухаан технологи, инновацын салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох зорилтын хүрээнд Үндэсний номын сангийн барилгыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулах.

БОАЖЯ:

- (9.3.4) Цаг уурын өртөөний 6 барилга барих.

ЗГХЭГ-ААС ХИЙСЭН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР ӨГСӨН ҮҮРГИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

2.25. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн эхний хагас жилийн биелэлт 51.7 хувьтай гарсан байна.

2.26. ЗГХЭГ-ын 2019 оны оны эхний хагас жилийн үнэлгээгээр “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 135 арга хэмжээнээс 14 нь 100 хувь, 37 нь 70 хувь, 67 нь 40 хувь, 12 нь 0 хувьтай хэрэгжиж, 5 арга хэмжээ үнэлэх

Боломжгүй гэж үнэлсэн бөгөөд Засгийн Газрын гишүүдэд дараах үүргийг өгсөн байна. Үүнд:

- Биелэлт хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай 79 арга хэмжээг 2019 оны зорилтот түвшинд хүргэх;
- Тухайн арга хэмжээг хамтран хэрэгжүүлж байгаа салбарын яам болон агентлагуудын ажлын уялдааг хангаж ажиллах;
- Арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинэжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу дунджийг зөв тооцож, үнэлэх,
- Арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тусгах.

2.27. Жилийн эцсийн үнэлгээгээр нийт 135 арга хэмжээнээс 63 нь 100 хувь, 48 нь 70 хувь, 14 нь 40 хувь, 6 нь 0 хувьтай хэрэгжсэн, 4 арга хэмжээ үнэлэх боломжгүй, дунджаар 78.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн бөгөөд эхний хагас жилээс 25.9 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 5. ЗГХЭГ-ын үнэлгээний судалгаа

Бодлого	эхний хагас жилийн үнэлгээ	жилийн эцсийн үнэлгээ
Макро эдийн засгийн бодлого	63.3	80.0
Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	40.3	61.0
Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	40.1	74.0
Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	60.9	89.3
Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	55.9	83.6
Дундаж үнэлгээ	52.1	78.0

Эх сурвалж: ЗГХЭГ-ын үнэлгээний тайлан

2.28. ЗГХЭГ-аас эхний хагас жилийн үнэлгээгээр биелэлт хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2019 оны зорилтот түвшинд хүргэх үүрэг өгсний дагуу арга хэмжээ авч ажилласнаар хэрэгжилтийн хувь дээшилсэн байна. Үүнд:

- 40 хувийн хэрэгжилттэй 67 арга хэмжээний 30 нь 100 хувь хэрэгжиж, 27 нь 70 хувь, 9 нь 40 хувийн хэрэгжилттэй болж, 1 нь 0 хувь буюу хэрэгжээгүй байна.
- 0 хувьтай буюу хэрэгжээгүй 12 арга хэмжээний 3 нь 70 хувь, 4 нь 40 хувийн хэрэгжилттэй болж, 5 нь хэрэгжээгүй хэвээр байна.
- Үнэлэх боломжгүй 5 арга хэмжээний 1 нь 40 хувийн хэрэгжилттэй болж, 4 нь үнэлэх боломжгүй хэвээр байна.

2.29. ЗГХЭГ-аас өгсөн тухайн арга хэмжээг хамтран хэрэгжүүлж байгаа салбарын яам, агентлагуудын ажлын уялдааг хангаж ажиллах, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хувийг Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу дунджийг зөв тооцож, үнэлэх, биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тусгах үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ БҮРЭН ТАЙЛАГНААГҮЙ, ТУХАЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ЭСЭХ, ТӨСЛИЙН ТАЙЛБАР ҮНДЭСЛЭЛД ТУСГАСАН ЭСЭХИЙГ НЯГТЛАХГҮЙГЭЭР ҮНЭЛЖЭЭ


2.30. Хэрэгжүүлэгч яам, агентлагууд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 135 арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд тайлагнаж хэвшсэн боловч зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр, хүрсэн түвшнийг бүрэн тайлагнаагүй зөрчил нийтлэг байна.

2.31. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийг Сангийн яам 81.4 хувь, ЗГХЭГ 78.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

2.32. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 135 арга хэмжээний биелэлтийг Сангийн яам, ЗГХЭГ дараах байдлаар үнэлжээ. Үүнд:

- Сангийн яам: 74 нь 100 хувь, 39 нь 70 хувь, 13 нь 40 хувьтай хэрэгжиж, 5 нь хэрэгжээгүй, 4 нь үнэлэх боломжгүй,
- ЗГХЭГ: 63 нь 100 хувь, 48 нь 70 хувь, 14 нь 40 хувьтай хэрэгжиж, 6 нь хэрэгжээгүй, 4 нь үнэлэх боломжгүй.

Дүрслэл 6. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт (хувиар)



Эх сурвалж: Сангийн яам, ЗГХЭГ-ийн үнэлгээ

2.33. YAG-аас аудитын явцад хэрэгжүүлсэн горим, судалгааны үр дүнгээр “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийг 76.9 хувийн хэрэгжилттэй, нийт арга хэмжээний 70 нь 100 хувь, 42 нь 70 хувь, 11 нь 40 хувь, 12 нь хэрэгжээгүй гэж үнэллээ.

2.34. Үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий байгууллагууд Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 5 дугаар зүйлийн 5.2.3⁶-т заасныг баримтлахгүйгээр арга хэмжээг тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх, төслийн тайлбар үндэслэлд тусгасан эсэхийг нягтлахгүйгээр тайланд тусган үнэлсэн байна.

2.35. Хэрэгжүүлэгч яам, агентлагаар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. Хэрэгжүүлэгч байгууллагуудын Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээний биелэлтийн судалгаа

№	Байгууллагын нэрс	Арга хэмжээ /тоо/	Хүрсэн түвшинд өгсөн үнэлгээ (хувиар)				YAG-ын үнэлгээ (арга хэмжээний тоогоор)			
			ТӨЗ	СЯ	ЗГХЭГ	YAG	хэрэгжсэн	хэрэгжилт дутуу		
								тодорхой үр дүнд хүрсэн	эрчимжүүлэх шаардлагатай	хэрэгжээгүй
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	8	81.3	76.3	76.3	76.3	5	1	1	1
2	Барилга, хот байгуулалтын яам	9	86.6	76.7	70.0	70.0	2	6	1	
3	Батлан хамгаалахын яам	5	94.0	88.0	88.0	88.0	3	2		
4	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	13	93.1	93.1	93.1	93.1	10	3		
5	Гадаад харилцааны яам	5	94.0	88.0	70.0	88.0	3	2		

⁶ хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах.

6	Зам, тээврийн хөгжлийн яам	6	78.3	75.0	75.0	68.3	2	3		1
7	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	5	82.0	70.0	64.0	56.0		4		1
8	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	21	96.3	90.0	88.3	73.3	14	2		5
9	Хууль зүй, дотоод хэргийн яам	10	100.0	94.0	94.0	94.0	9		1	
10	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	13	72.3	61.5	59.2	61.5	3	6	2	2
11	Сангийн яам	2	100.0	100.0	85.0	85.0	1	1		
12	Эрүүл мэндийн яам	8	81.3	76.3	76.3	76.3	4	3		1
13	Эрчим хүчний яам	10	70.0	63.0	56.0	60.0	3	2	4	1
14	Монголбанк	4	97.5	85.0	77.5	77.5	1	3		
15	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2	100.0	100.0	85.0	85.0	1	1		
16	Онцгой байдлын ерөнхий газар	3	90.0	80.0	80.0	80.0	2		1	
17	Үндэсний хөгжлийн газар	1	100.0	100.0	100.0	100.0	1			
18	Санхүүгийн зохицуулах хороо	1	70.0	70.0	70.0	70.0		1		
19	Стандарт хэмжил зүйн газар	3	90.0	70.0	70.0	70.0	1	1	1	
20	Төрийн албаны зөвлөл	1	100.0	100.0	100.0	100.0	1			
21	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	1	70.0	70.0	70.0	70.0		1		
22	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	4	100.0	100.0	100.0	100.0	4			
Нийт дүн		135	87.9	81.4	78.0	76.9	70	42	11	12

Эх сурвалж: Хэрэгжүүлэгч яам, агентлагуудын тайлан, СЯ, ЗГХЭГ-ын үнэлгээний тайлан

2.36. Зөвлөхийн судалгааны тайланд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмыг үндэслэн Үндсэн чиглэлийн арга хэмжээний биелэлтэд жил бүр ТЕЗ-ийн Дотоод хяналтын нэгж, Сангийн яам, ЗГХЭГ, ҮАГ үнэлгээ хийсэн боловч тус байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээ зөрүүтэй байгаа нь дараах шалтгаанууд нөлөөлсөн байна гэж дурджээ. Үүнд:

- Нэгдсэн арга зүй байхгүй,
- Үнэлгээний зөрүүг нэгдсэн зөвшилцлөөр шийдвэрлээгүй,
- Үнэлгээний арга зүйг өөрсдийнхөөрөө ойлгосон.

2.37. УИХ-ын 2011 оны 34 дүгээр тогтоолыг үндэслэн ҮАГ-аас “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтэд жил бүр хийсэн аудитаар өгсөн үнэлгээгээр өмнөх шатны байгууллагуудын үнэлгээ буурч үнэлэгддэг, илэрсэн зөрчлүүд дахин давтагдан гардаг, өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлдэггүй нь аудитын ач холбогдлыг бууруулж байна.

2.38. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар 8 заалт бүхий зөвлөмж өгснөөс Сангийн сайдад өгсөн 1 зөвлөмж хэрэгжсэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад өгсөн 5 заалт бүхий зөвлөмж хэрэгжих шатанд, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн 2 заалт бүхий зөвлөмж хэрэгжээгүй байна.

2.39. ҮАГ-аас 2013-2019 онд үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар УИХ, ЗГХЭГ, Сангийн яам болон бусад хэрэгжүүлэгч яам, агентлагуудад арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тооцоо, судалгаанд үндэслэн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, үндэслэлтэй төлөвлөх, хамтран хэрэгжүүлэгч яам, байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хариуцлагыг сайжруулах зөвлөмжийг жил бүр өгсөн боловч зөрчлүүд давтагдан гарсаар байна.

2.40. Энэ нь үндсэн чиглэлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны үр дүн, чанарыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

ЗГХЭГ-ААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ~~20~~ он ~~04~~ дугаар
сарын ~~20~~-ны өдөр

Дугаар ~~ХЭТ/~~
11018

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ


Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох тайлбарыг хүргүүлж байна.

Тайлбарт дурдсан мэдээллийг харгалзан үзэж Үндсэн чиглэлд заасан зарим арга хэмжээний гүйцэтгэлийг дахин хянан үзэх арга хэмжээ авна уу.

Хавсралт: ..4.. хуудастай.

Дэд дарга



У.БЯМБАСҮРЭН

2056591



Үзүүлэлт		Ирүүлсэн санал, тайлбар										
1. "2.2. Хэрэгжүүлэгч яам, агентлагууд арга хэмжээний биелэлтийн тайланд тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй, үндсэн чиглэлийн төслийн тайлбар үндэслэл тусгаагүй арга хэмжээний биелэлтээр тайлагнасан дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:												
Тайлбар 1-ийг үзнэ үү.	<p>БХБЯ:</p> <ul style="list-style-type: none"> (8.3) Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх арга хэмжээний хүрээнд Архангай, Завхан, Хэнтий, Орхон, Өвөрхангай, Дархан-Уул зэрэг 6 аймаг, Өвөрхангай аймгийн Хар-Хорин сум, Замын-Үүд, Алтанбулаг 2 чөлөөт бүс зэрэг 9 хот, сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх, шинээр боловсруулахаар төлөвлөсөн боловч биелэлтийг тайлагнахаа тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй өөр аймгуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтээр тайлагнасан; гэжээ. 	<p>Тайлбар: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 8.3-д заасан Архангай, Завхан, Хэнтий зэрэг 6 аймаг, Замын-Үүд, Алтанбулаг зэрэг 3 чөлөөт бүс, нийт 9 хот, сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх, шинээр боловсруулах хүрээнд хийгдсэн ажлуудаа дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд 2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй өөр аймгуудыг тайлагнаагүй болно. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг даган хөгжих Багануур хот, Ховд, Дорнод аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2017 онд батлагдсан ба олон улсын нисэх онгоцны буудлыг даган бий болох шинэ хот "Аэросити", Төв аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2019 онд хэлэлцүүлэн, батлуулсан. Архангай аймгийн Цэцэрлэг хотын ХЕТ-г ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар тогтоолоор, Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын ХЕТ-г ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/05 дугаар тогтоолоор тус тус батлуулсан байна. "Алтанбулаг", "Бичигт", "Замын-Үүд" хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг яамны ШУТТЗ-ийн хурлаар 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцүүлэн, дэмжигдсэн.</p>										
	<p>БОАЖЯ:</p> <ul style="list-style-type: none"> (9.6) Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу үйлчилгээний В цогцолбор байгуулах арга хэмжээг 50 хувьд хүргэх арга хэмжээний хүрээнд Булган аймгийн Рашаант сумын нутаг Элсэн тасархайн бүсэд төр, хувийн хэвшлийн түншлэлээр түр буудаллах цэг байгуулахаар төлөвлөсөн боловч биелэлтийг өөр байршилд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтээр тайлагнасан; гэжээ. 	<p>Тайлбар: Булган аймгийн Рашаант сумын нутаг Элсэн тасархайн бүсэд төр, хувийн хэвшлийн түншлэлээр цэг байгуулахаар төлөвлөсөн боловч биелэлтийг өөр байршилд хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн нь улсын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын биелэлтийг тусгаж, Булган аймгийн Рашаант суманд хувийн хэвшлийн хөрөнгөөр үйлчилгээний цогцолбор ашиглалтад оруулсныг тодруулж бичээгүйтэй холбоотой гэж үзэж байна. Тус ажил төлөвлөлтийн дагуу тогтоосон байршилд 100 хувь хэрэгжсэн. Тус ажлын хүрээнд хувийн хэвшлийн байгууллагад 2 га газар олгоглын асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран дэмжлэг үзүүлж ажилласан тул биелэлтийг тооцох шаардлагатай гэж үзэж байна. Энэхүү зорилт, арга хэмжээний хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр нийт 237.5 сая төгрөг, Хувийн хэвшлийн 1.0 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. Тухайлбал: Богдхан уулын ДЦГ болон Булган аймгийн нутаг орших Түлүүгийн даваанд аялагчдад зориулсан ариун цэврийн байгууламж барьсан, Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газарт 2 отоглох цэг тохижуулсан, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт үйлчилгээний цогцолбор төв байгуулах ажлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулах ажлыг эхлүүлсэн, 2019 онд нийт 2 ариун цэврийн байгууламж, зохих тэмдэг тэмдэглэгээ, авто зогсоол бүхий 4 түр буудаллах цэг, 4 отоглох цэг байгуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн, Дорноговь аймгийн Хамрын хийдэд шашны аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох ажлыг 100 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж, 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр хүлээн авсан. Өвөрхангай аймгийн Хархорин суманд жуулчдад зориулсан задгай театр байгуулах ажлыг 200 сая төгрөгийн санхүүжилтээр 2019 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан.</p>										
Тайлбар 3-ыг үзнэ үү.	<p>ГХЯ:</p> <ul style="list-style-type: none"> (19.4.1) Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд Чикаго, Ванкувер хотод Ерөнхий консулын газар нээхээр төлөвлөсөн боловч биелэлтийг 2019 онд БНХАУ-ын Шанхай хот болон 2020 онд Манжуур хотод Консулын газар нээсэн гэж тайлагнасан." гэжээ. 	<p>Тайлбар: УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 19.4-т "Чикаго, Ванкувер хотод Ерөнхий консулын газар нээх" гэж батлагдаагүй харин шинээр нээж ажиллуулах Ерөнхий консулын газар 2 гэж батлагдсан болно.</p>										
	<table border="1"> <tr> <td>19.4</td> <td>ГБҮБ-ын 6.27.5 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.3.12, 5.6.9, 5.6.12 дахь заалт</td> <td>Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх</td> <td>Шинээр нээж ажиллуулах Ерөнхий консулын газар</td> <td>2</td> <td>-</td> <td>ГХЯ</td> </tr> </table>	19.4	ГБҮБ-ын 6.27.5 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.3.12, 5.6.9, 5.6.12 дахь заалт	Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх	Шинээр нээж ажиллуулах Ерөнхий консулын газар	2	-	ГХЯ	<p>Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 16 дугаар тогтоолоор БНХАУ-ын Шанхай хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулахаар шийдвэрлэж, 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр үйл ажиллагааг нь эхлүүлэв. БНХАУ-ын Манжуур хотод Консулын газар нээх асуудлыг 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар, 10 дугаар сард УИХ-аар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв. Хятадын талд 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр А/19-2242 тоот ноот бичиг хүргүүлж, айлын талтай ажлын шугамаар тохиролцсоны дагуу ТЗУГ-ын захирал Н.Анхбаяр, КГ-ын захирал Л.Мөнхтүшиг нар Манжуур дахь КГ-ын байрлах албаны байрны судалгаа хийх ажлаар 2019 оны 11 дүгээр сард тус хотод албан томилолтоор ажилласан. Улмаар 2020 оны 01 дүгээр сарын 9-ний өдөр Манжуур дахь КГ-ыг нээх зөвшөөрөл бүхий хариу ирүүлээд байна.</p> <p>Өмнөх жилүүдэд санал яригдаж байсан боловч ЕКГ нээх хэмжээний иргэд оршин суудаггүй гэсэн шалтгаанаар Ванкуверт ЕКГ нээх асуудал түр хойшилсон. Чикагод ЕКГ нээх асуудлаар Вашингтон дахь ЭСЯ айлын талтай</p>			
19.4	ГБҮБ-ын 6.27.5 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.3.12, 5.6.9, 5.6.12 дахь заалт	Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх	Шинээр нээж ажиллуулах Ерөнхий консулын газар	2	-	ГХЯ						

		санал мэдээлэл солилцож ажиллаж байна. Иймд 2019 оны ГХЯ-ны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Чикаго, Ванкуверт ЕКГ нээх асуудал тусгагдаагүй болно.
2.	2.34.	ҮАГ-аас аудитын явцад хэрэгжүүлсэн горим, судалгааны үр дүнгээр “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийг 75.9 хувийн хэрэгжилттэй, нийт арга хэмжээний 69 нь 100 хувь, 42 нь 70 хувь, 11 нь 40 хувь, 13 нь хэрэгжээгүй гэж үнэллээ.
Тайлбар үзнэ үү.	4-ийг	<p>Хэрэгжээгүй гэж үнэлсэн дараах арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 онд холбогдох бүх тооцоо, судалгаа хийж төсвийг УИХ-аар батлуулсан болно.</p> <p>16.10. Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх Тайлбар: Энэхүү арга хэмжээг хуулийн өөрчлөлтийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлнэ. Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар уг арга хэмжээнд 4.7 тэрбум төгрөг зарцуулахаар УИХ-аар батлуулсан.</p> <p>16.11. Төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан 1 жилийг 1.5 жилээр тооцох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах Тайлбар: Энэхүү арга хэмжээг 2020 оны 01 дүгээр сарны 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэхээр шийдвэрлэсэн бөгөөд Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар ээжүүдийн тэтгэвэрт 6.0 тэрбум төгрөг зарцуулахаар УИХ-аар батлуулсан.</p> <p>16.12. 0-3 насны хүүхдээ асарч буй ээжүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тасрахгүй байх нөхцөл бүрдүүлэх Тайлбар: Энэхүү арга хэмжээг 2020 оны 01 дүгээр сарны 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлнэ. 2019 онд арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг боловсруулан ээжүүдийн шимтгэлд 2020 онд нийт 16.2 тэрбум төгрөг зарцуулахаар УИХ-аар батлуулсан.</p>
Тайлбар үзнэ үү.	5-ыг	<p>16.19. Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Тайлбар: Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг хийсэн байхад хэрэгжээгүй гэж үнэлсэнтэй санал нийлэхгүй байна. Жендерийн салбар хороо, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд баримтлах жендерийн дэд хөтөлбөр боловсруулах, батлуулах ажлын хүрээнд 2019 онд 4 аймгийн дэд хөтөлбөр батлагдаж, 3 аймаг дэд хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлээд байна. 2 салбар жендерийн бодлого батлуулав. Тухайлбал, геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого болон батлан хамгаалах салбарын жендерийн талаар баримтлах бодлого батлагдав. Орон нутгийн түвшинд нийт 20 удаагийн сургалтаар 536 төрийн албан хаагчдад жендерийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт семинарыг зохион байгууллаа.</p>
Тайлбар үзнэ үү.	6-г	Тайлангийн төслийн “2.35. Үндсэн чиглэлийн арга хэмжээний биелэлтийг тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх, төслийн тайлбар үндэслэлд тусгасан эсэхийг нягтлахгүйгээр үнэлсэн байна” мөн Зөвлөмж хэсэгт “тайлбар үндэслэлд тусгасан эсэхийг хянаж, үнэлэх” гэсэн хэсгийг 2.2-т хийсэн тайлбарыг үндэслэн тус тус хасах саналтай байна.

ҮАГ-ЫН ТАЙЛБАР

ЗГХЭГ-аас ирүүлсэн 4 тайлбарыг хүлээн авч, тайлангийн төсөлд өөрчлөлт оруулж, 1 тайлбар, 1 саналыг хүлээн авах боломжгүй байна.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Тайлбарыг хүлээн авч, тайлангийн төсөлд тусгав.
Тайлбар 2	Тайлбарыг хүлээн авч, тайлангийн төслөөс хасав.
Тайлбар 3	Тайлбарыг хүлээн авч, тайлангийн төсөлд тусгав.
Тайлбар 4	<p>“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д:</p> <ul style="list-style-type: none"> • (16.10) Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх НДС-ийн 4.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж, 100 хувь хэрэгжүүлэх, • (16.11) Төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан 1 жилийг 1.5 жилээр тооцох хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг НДС-ийн 7.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж, 100 хувь хэрэгжүүлэх, • (16.12) 0-3 насны хүүхдээ асарч буй ээжүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тасрахгүй байх нөхцөл бүрдүүлэх арга хэмжээг улсын төсвийн 16.0 тэрбум төгрөг, НДС-ийн 3.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж, 50.0 мянгаас доошгүй эхчүүдийг хамруулахаар баталсан боловч Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9-д “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна” гэсэн заалтад нийцүүлээгүй, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд дээрх арга хэмжээний санхүүжилтийг батлаагүйгээс хэрэгжих боломжгүй болсон тул тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 5	Тайлбарыг хүлээн авч, тайлангийн төсөлд тусгав.
Тайлбар 6	Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2-т “хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах” гэж заасныг баримтлахгүйгээр тайланд тусгасан арга хэмжээг тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх, төслийн тайлбар үндэслэлд тусгасан эсэхийг нягтлахгүйгээр үнэлсэн тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

САНГИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Хүн амын үйлчилгээний газар
Улаанбаатар, 100110
Телефон: 7711 25 44 80, 7711 25 44 81
Факс: 7711 25 44 82
Электрон хуудас: www.msa.gov.mn

2020.04.21 № 5-2/2021
Тангид 2020.04.15-ны № 12/1138-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.ТЭНГИС
ТАНАА

Санал өгөх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2 дахь заалтад заасны дагуу танаа газраас "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг үндэслэн жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж байна.

Мөн Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр", улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэл болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах зарчмыг баримталсан болно.

Тайлангийн төсөлд дараах саналтай байна. Үүнд:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төслийг Төсвийн хүрээний мэдэгдэл, мөн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ирүүлсэн саналыг төсвийн боломж, дунд хугацааны төсөөлөлд нийцүүлэн боловсруулдаг учраас ирүүлсэн бүх саналыг тусгах боломжгүй тул тайлангийн төслийн 1.2-т тусгагдсан "...Үндэсний хөгжлийн газраас албан бичгээр ирүүлсэн зарим саналыг тусгаагүй байна." гэсэн дүгнэлтийг хасах;

2. Улсын Их Хурлаар үндсэн чиглэлийн төслийг хэлэлцүүлэх үеэр гишүүдээс гарсан саналууд нэмэгддэг тул тайлангийн төслийн 1.6-д "холбогдох тооцоо судалгаагүйгээр төсөл, арга хэмжээг нэмж баталсан..." гэсний оронд бодлогын санал өгөх, түүнчлэн хаана нэмэгдүүлснийг тодорхой заах;

3. Үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахаас гадна Төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн боловсруулдаг. Нэг талаар төсөв боломжгүй байгаа нөхцөлд бүх ирүүлсэн саналыг тусгах, мөн нөгөө талаар төсвийн бүх асуудлаа Үндсэн чиглэлд буулгах боломжгүй тул тайлангийн төслийн 1.14-т тусгагдсан "Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна" гэсэн заалтад нийцүүлэн тухайн жилийн

Тайлбар 1-ийг
үзнэ үү.

Тайлбар 2-ыг
үзнэ үү.

Тайлбар 3-ыг
үзнэ үү.

9761 04563



төсвийн хязгаар, төсвийн төслийг төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.” гэсэн дүгнэлтийг дахин авч үзэх;

Тайлбар
4-ийг
үзнэ үү.

4. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “...Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд хөгжлийн бодлого, зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, тухайн жилд хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн томоохон арга хэмжээ, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн уялдаа, хөрөнгийн эх үүсвэр, хариуцан хэрэгжүүлэх яам, байгууллагыг тусгана.” гэж заасан байдаг тул гүйцэтгэлийн тайлангийн төслийн 1.9-д тусгагдсан “хүрэх түвшнийг тодорхой тусгаагүй, хэрэгжих боломжтой хугацааг үндэслэлтэй тооцож төлөвлөөгүй, шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоогоогүй, судалгаа шинжилгээнд үндэслэхгүйгээр хэт ерөнхий төлөвлөсөн...” гэх тайлбар үндэслэлийг нягтлах;

Тайлбар
5-ыг үзнэ
үү.

5. Үндсэн чиглэл нь богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг бөгөөд түүний зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүдийг Засгийг газрын 2016 оны 249 дүгээр журамд заасанчлан бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд гарах өөрчлөлтийг илэрхийлсэн байдлаар тодорхойлон тусгадаг. Харин Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын тухайн жилийн төсвийг батлахдаа тухайн жилийн батлагдсан үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээг байгууллагын нэр, байршил, санхүүжилтийн дүн тус бүрээр дэлгэрэнгүй задлан, төсөл хөтөлбөрөөр ангилан баталдаг. Тухайлбал, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 15.5-д “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж үйлчилгээнээс үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх” арга хэмжээг нийт 11 эмнэлгийг шинээр ашиглалтад оруулж, тоног төхөөрөмжүүдийг 100 хувь чанарын хяналтын баталгаажуулалтад хамруулж, нэг удаагийн хэрэгслийн хангамжийг 50 хувьд хүргэснээр биелэлтийг хангаж, түүнд 57.0 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Харин эдгээр 11 эмнэлэг, тоног төхөөрөмжийн задаргааг Төсвийн тухай хуулийн дагуу төсөл хөтөлбөрийн ангиллаар Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар нарийвчлан баталсан. Иймд тайлангийн төслийн 1.15-д тусгагдсан “ЭМЯ: ...байгууллагын нэр, тоо, тоног төхөөрөмжөөр хангах байгууллагын тоо, нэр төрөл, тодорхой тусгаагүй, санхүүжилтийн эх үүсвэрийг нарийвчлан төлөвлөөгүй.” гэснийг дахин авч үзэх;

Тайлбар
6-г үзнэ
үү.

6. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр нь санхүүжүүлдэг, ажил удаашраад санхүүжилтээ аваагүй байгаа нь буруу төлөвлөлтөөс шалтгаалахгүй бөгөөд зохион байгуулалтын асуудал тул тайлангийн төслийн 1.17-д тусгагдсан дүгнэлтийг хасах;

Тайлбар
7-г үзнэ
үү.

7. Уул уурхай, эрчим хүч, зам, тээврийн салбарт хэрэгждэг томоохон төсөл, хөтөлбөрүүд нь олон жил үргэлжлэн хэрэгждэгээс гадна их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагддаг. Хэрэгжилтийг явцад гэрээ хэлэлцээрийн асуудал гаднын хүчин зүйлээс шалтгаалж удаашрах, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулаагүй төслүүдийн хувьд хүрэх түвшин шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан төлөвлөх нь хүндрэлтэй байдаг тул тайлангийн төслийн 2.25-д тусгагдсан “гадаад эх үүсвэр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байхад зарим арга хэмжээний хүрэх түвшнийг хэрэгжих боломжтой хугацаагаар тооцож төлөвлөгөөгүйгээс...хэрэгжээгүй” гэсэн тайлбарыг тодорхой болгох;

Тайлбар
8-ыг үзнэ
үү.

8. Тайлангийн төсөлд “Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хийсэн эхний хагас жилийн үнэлгээгээр хэрэгжээгүй арга хэмжээний шалтгаан нөхцөлийг

тодорхойлж, эрчимжүүлэх талаар хэрэгжүүлэгч яам, агентлагуудад үүрэг өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна” гэсэн дүгнэлт өгсөн боловч, мөн төслийн 2.31-д “Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ...үүрэг өгсний дагуу хэрэгжилтийн хувь дээшилсэн байна.” гэж хоорондоо зөрүүтэй үнэлэлт, дүгнэлтийг авч үзэх зэрэг саналтай байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ

ҮАГ-ЫН ТАЙЛБАР

Сангийн яамнаас ирүүлсэн 2 тайлбарыг хүлээн авч, тайлангийн төсөлд нэмэлт тодруулгыг оруулж, 6 тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Тайлангийн төслийн 1.2-т тусгагдсан “...Үндэсний хөгжлийн газраас албан бичгээр ирүүлсэн зарим саналыг тусгаагүй байна” гэсэн дүгнэлт нь тус газартай холбоотойгоос гадна Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан нийт арга хэмжээтэй хамааралтай бөгөөд тайлангийн төсөлд жишээгээр оруулсан тул хасах боломжгүй байна.
Тайлбар 2	Тайлангийн төслийн 1.6-д “холбогдох тооцоо судалгаагүйгээр төсөл, арга хэмжээг нэмж баталсан ...” гэснийг нэмэгдсэн арга хэмжээ бүрээр Хүснэгт 3-т харуулсан, УИХ-ын анхааралд толилуулах асуудалд тусгасан тул хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 3	Тайлангийн төслийн 1.14-т “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9-д “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна” гэж заасантай нийцүүлэн тухайн жилийн төсвийн хязгаар, төсвийн төслийг төлөвлөөгүйгээс шалтгаалжээ” гэсэн дүгнэлтийн жишээг тайлангийн төсөлд тусгасан, өмнөх жилд өгсөн зөвлөмж хэрэгжээгүй тул хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 4	Тайлангийн төслийн 1.9-д “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн арга хэмжээг Засгийн Газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого боловсруулах нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтаар төлөвлөсөн боловч тухайн жилд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хүрэх түвшнийг тодорхой тусгаагүй, хэрэгжих боломжтой хугацааг үндэслэлтэй тооцож төлөвлөөгүй, шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоогоогүй, судалгаа шинжилгээнд үндэслэхгүйгээр хэт ерөнхий байдлаар төлөвлөсөн байна.” гэсэн нь зарим арга хэмжээтэй холбоотой бөгөөд жишээг тайлангийн төсөлд тусгасан тул тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 5	Тайлбарыг хүлээн авч, тайлангийн төсөлд тусгав.
Тайлбар 6	Тайлангийн төслийн 1.17-д “Баталсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц санхүүжилтийг тооцоо судалгаанд үндэслэн бодитой тооцож, төлөвлөөгүйгээс санхүүжилтийн эх үүсвэргүй болох, дутагдах зэрэг нөхцөл байдал бий болсноос арга хэмжээ хэрэгжихгүй, дутуу хэрэгжих үр дагавар үүсч байна.” гэсэн дүгнэлтэд хамаарах санхүүжилт батлагдаагүйгээс шалтгаалан хэрэгжээгүй арга хэмжээний жишээг тайлангийн төслийн 2.20-2.24 дэх хэсэгт оруулсан тул хасах боломжгүй байна.
Тайлбар 7	Тайлангийн төслийн 2.23-т “Гадаад эх үүсвэр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байхад зарим арга хэмжээний хүрэх түвшнийг хэрэгжих боломжтой хугацаагаар тооцож төлөвлөөгүйгээс дараах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна” гэсэн нь зарим арга хэмжээтэй холбоотой бөгөөд жишээг тайлангийн төсөлд тусгасан тул тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 8	Тайлбарыг хүлээн авч, тайлангийн төсөлд тусгав.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зарим арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, журамд нийцүүлэн тооцоо судалгаанд үндэслээгүй, хэрэгжих боломжтой хугацаа, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг оновчтой тогтоохгүйгээр төлөвлөсөн зөрчил бүрэн арилахгүй байна.
- Баталсан арга хэмжээ бүрд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн бодитой тооцоогүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутагдаж, төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй, дутуу хэрэгжих үр дагавар үүсч байна.
- Үндсэн чиглэлийн арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд багтаан хэрэгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх асуудлыг холбогдох байгууллагууд хангалттай зохион байгуулаагүй, ЗГХЭГ-аас 2019 оны эхний хагас жилд хийсэн үнэлгээгээр өгсөн үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээний биелэлтэд дотоод хяналт хийх чиг үүрэг бүхий байгууллагууд арга хэмжээг тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх, төслийн тайлбар үндэслэлд тусгасан эсэхийг нягтлахгүйгээр үнэлсэн байна.
- УАГ-аас 2013-2018 онд үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар УИХ, ЗГХЭГ, Сангийн яам болон бусад хэрэгжүүлэгч яам, агентлагуудад дээр дурдсан зөрчлийг арилгах, хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоо, ажлын хариуцлагыг сайжруулах зөвлөмжийг жил бүр өгсөн боловч зөрчлүүд дахин давтагдан гарсаар байна.

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

1. Засгийн Газраас өргөн барьсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцэж шийдвэр гаргахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын урьдчилсан судалгаа хийгдээгүй, ТЭЗҮ, зураг, төсөлгүй, бэлтгэл ажил хангагдаагүй, санхүүжилтийн эх үүсвэргүй арга хэмжээг нэмж батлахгүй байх;
2. УИХ-ын 2011 оны 34 дүгээр тогтоолын 2-т “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн биелэлтэд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайланг Улсын Их Хуралд ирүүлж байхыг Үндэсний аудитын газарт үүрэг болгосугай” гэж заасныг эргэн хянаж, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.10 дахь заалттай уялдуулан УАГ-аас Засгийн газрын мөрийн хөтөлбөр буюу дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд аудит хийх талаар эрх зүйн зохицуулалттай болгох асуудлыг тус тус толилуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Засгийн Газрын Хэрэг эрхлэх газарт:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах явцад хяналт-шинжилгээ хийхдээ биелэлтийн тайланг иж бүрэн гаргасан эсэх, арга хэмжээг тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх, төслийн тайлбар үндэслэлд тусгасан эсэхийг хянаж, үнэлэх;
2. Үндсэн чиглэлд баталсан арга хэмжээг хангалтгүй биелүүлсэн, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох.

Сангийн сайдад:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээг хууль, журмын дагуу тооцоо судалгаанд үндэслэн тухайн жилд хэрэгжих боломжтой хугацаа, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнээр оновчтой тогтоох, санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөх, тайланд тусгасан арга хэмжээг тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилттой нийцсэн эсэхийг хянаж, үнэлэх.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээг хууль, журамд нийцүүлэн тухайн жилд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх;
2. Үндсэн чиглэлийн арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, биелэлтийн тайланд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хүрсэн түвшнийг журамд нийцүүлэн бүрэн тодорхойлж тайлагнах;
3. Аудитын тайланд тусгагдсан хэрэгжээгүй, дутуу хэрэгжсэн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангахад анхаарч, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлж ажиллах.

Монголбанкнд:

1. Хамтран ажиллах байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан банк, санхүүгийн тогтолцооны эрсдэл даах чадавх болон санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг эрчимжүүлж, валютын орох урсгал өндөр үед гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж ажиллах.

ХАВСРАЛТ 1. ХЭРЭГЖЭЭГҮЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

№	Бодлого	Бодлогын баримт дугаар	Арга хэмжээ	Хариуцах байгууллага
1	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	4.3	Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах	ХХААХҮЯ
2		4.8	Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн парк байгуулах	
3		5.4	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	УУХҮЯ
4		6.2	Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, Өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих	ЭХЯ
5		7.6	Орон нутгийн нисэх буудлуудын чадавхыг дээшлүүлэх	ЗТХЯ
6	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	9.10	Цөлжилт, газрын доройтлыг бууруулах	БОАЖЯ
7	Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого	15.7	Сүрьеэгийн эмнэлгийн барилга шинээр барих /360 ортой/	ЭМЯ
8		16.8	Ядуу хүн амын эрэлт хэрэгцээнд тохирсон халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээг бүлэг тус бүрд ялгавартайгаар хүргэх	ХНХЯ
9		16.10	Хүүхэд төрүүлсэн эхэд даатгуулсан хэлбэрээс үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	
10		16.11	Төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан 1 жилийг 1.5 жилээр тооцох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	
11		16.12	0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тасрахгүй байх нөхцөл бүрдүүлэх	
12		16.17	Төр, хувийн хэвшил, олон нийтийн дэмжлэгтэйгээр ахмад настны эрх, хөгжил, хамгааллыг сайжруулж, нийгмийн харилцаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх	

ХАВСРАЛТ 2. ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

№	Бодлого	Бодлогын баримт дугаар	Арга хэмжээ	Хариуцах байгууллага
1	Эдийн засгийн өсөлтийг дэмжих	3.2	Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийх, мал аж ахуйн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, түүний техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх	ХХААХҮЯ
2	салбаруудын бодлого	4.5	“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлэх	
3		6.3	Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлэх	ЭХЯ
4		6.4	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх	
5		6.6	Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	
6		6.8	Метан хийг ашиглах боломжит нөөцийг бүрдүүлэх судалгааг эрчимжүүлэх, хийн хангамжийг хөгжүүлэх эрх зүй, дэд бүтцийн орчныг бүрдүүлэх, нүүрснээс цэвэр түлш гарган авах үйлдвэр барих төслийг эхлүүлэх	
7	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил,	8.4	Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих болон өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх	БХБЯ
8	байгаль орчны бодлого	9.3	Цаг уур, орчны шинжилгээний техник, технологийн шинэчлэл, сүлжээний өргөтгөл хийх	БОАЖЯ
9		10.3	Гамшгийн үед ашиглах нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах механикжсан хүнсний болон шатахууны агуулахыг барих	ОБЕГ
10	Засаглал, эрх зүйн шинэчлэл,	17.1	Шүүхийн шинжилгээний тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	ХЗДХЯ
11	гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	18.2	Улсын эталоны нарийвчлалын түвшнийг дээшлүүлж, баталгаажуулалтын болон эталон лабораторийг байгуулах	СХЗГ



ХАВСРАЛТ 3. ХЭРЭГЖИЛТ ДУТУУ АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

№	Бодлого	Бодлогын баримт дугаар	Арга хэмжээ	Хариуцах байгууллага	
1	Макро, эдийн засгийн бодлого	1.1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 8 хувьд хүргэх	СЯ	
2		1.2	Зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэж, хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх	ХНХЯ	
3		2.2	Валютын орох урсгал өндөр үед гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх	МБ	
4		2.4	Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин, дэд бүтцийг боловсронгуй болгож, бизнес эрхлэгчдэд хямд өртөгтэй санхүүжилт татах боломжийг бүрдүүлэх	СЗХ	
5		2.5	Банк, санхүүгийн тогтолцооны эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх	МБ	
6		2.7	Зээлийн хүүг бууруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг эрчимжүүлэх		
7	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	3.1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	ХХААХҮЯ	
8		3.4	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулах		
9		4.2	Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хангалтыг нэмэгдүүлэх		
10		4.4	Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутгийн тариалалтыг дэмжих		
11		4.6	"Ноолуур" хөтөлбөр хэрэгжүүлэх		
12		4.9	Төрөөс дотоодын худалдан авалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх		
13		4.10	Орон нутгийн мэргэжлийн хяналтын лабораторийн ажиллах нөхцөлийг сайжруулах		МХЕГ
14		5.1	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх		УУХҮЯ
15		5.2	Нутаг дэвсгэрийн ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах, геозкологи, гидрогеологийн судалгаа хийх, геомэдээллийн санг баяжуулах сэдэвчилсэн судалгааны ажлыг гүйцэтгэх		
16		5.3	Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх		
17	5.5	Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөнөөр болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулан, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны эзлэх хувийг нэмэгдүүлэх			
18	6.1	Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх	ЭХЯ		
19	6.5	Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг эхлүүлэх			
20	7.2	Авто замын засвар, арчлалтын хугацааг уртасгах, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах	ЗТХЯ		
21	7.3	Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан авто замын сүлжээг сайжруулах, түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээ авах			
22	7.5	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх			
23	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	8.1	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулах	БХБЯ	
24		8.2	Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох		
25		8.3	Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх		
26		8.5	"Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх		

27		8.6	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд инженерийн дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх	
28		8.7	Гэр хороололд амины орон сууц барихад зориулж урт хугацааны хөнгөлөлттэй нөхцөлөөр ипотекийн зээл олгох	
29		9.6	Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу үйлчилгээний цогцолборыг байгуулах	БОАЖЯ
30	Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого	11.4	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгох	БСШУСЯ
31		12.4	2020 онд Герман болон Европын бусад орнуудад Чингис хааны өмнөх болон дараах үеийн түүх, археологийн үзэсгэлэн гаргах бэлтгэл ажиллагааг хангах	
32		13.4	Шинжлэх ухаан технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох	
33		15.2	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эмчилгээ, оношилгооны чанарыг сайжруулах	ЭМЯ
34		15.3	Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт, сэргийлэлтийг сайжруулж, өвчний тохиолдлыг бууруулах	
35		15.5	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж үйлчилгээнээс үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх	
36		16.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд зохион байгуулалттай болон хувь хүний ур чадварт түшиглэсэн ажлын байр бий болгох	ХНХЯ
37	Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	18.3	Олон улсын итгэмжлэлийн байгууллагын хэлэлцээрт нэгдэх	СХЗГ
38		18.4	Төрийн өмчийн талаарх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, удирдлага менежментийг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах үйл ажиллагааг ил тод болгох, өрсөлдөх тэгш боломжоор хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	ТӨБЗГ
39		19.3	Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	ГХЯ
40		19.4	Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх	
41		20.3	НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд инженерийн ротыг бэлтгэж, оролцуулах	БХЯ
42		20.4	Материал, хэрэгслийн нөөцийг зэвсэгт хүчний хэмжээнд оновчтой шилжүүлэн байршуулах ажлыг зохион байгуулах	

